



СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2021 ОН

Гарчиг

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн 3
2. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн 4-6
3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн 6-37
4. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал 37-38
5. Цаг үеийн шаардлагаар хийсэн ажлын үр дүн 38-54

СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ.

Өргөө нь Монгол Улсын хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 хөтөлбөр, Улсын Их Хурлаас 2012 онд баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Засгийн Газраас батлагдсан төсөл хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл урлагийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх” зорилтууд, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөхөөр батлагдсан дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал:

- Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар төрийн үйлчилгээний албанд тавигддаг зарчим, шаардлага болон холбогдох заалтууд, нийслэлийн өмчийн эд хөрөнгийг бэлтгэх, бүртгэх, ашиглах, хамгаалах, түрээслэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Архивын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, НИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж ирлээ.
- “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, нийслэлийн хүн ам, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн нэгдмэл цогц, харилцан уялдаатай, давхардалгүй, хүртээмжтэй, бүх нийтийн оролцоог хангасан байх зарчмуудыг баримтлан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” төлөвлөлтийн баримт бичигт дэвшүүлсэн зорилтыг байгууллагынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллаж байна.

Гэвч “Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийслэлийн иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах” талаар Засгийн газар, Улсын болон нийслэлийн онцгой комисс, Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэхэд байгууллага,

хамт олон идэвх санаачлага гарган, иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлахад хяналт тавих хариуцлагатай жижүүр-эргүүл хийх, мөн ариутгал, цэвэрлэгээг чанарын өндөр түвшинд хийж, арга хэмжээ, телевизийн бичлэгийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэх зэрэг тусгай үүргүүдийг амжилттай хэрэгжүүллээ.

Хоёр: Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн

2.1. Байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа

Байгууллагын үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хавсралтын дагуу бодлогын баримт бичиг, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн байдлаар гаргаж, холбогдох материалын хамт НЗДТГ-ын Хяналт Шинжилгээ Үнэлгээний хэлтэст хүргүүлж хэвшсэн болно.

2.2. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт.

Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоол, Засгийн газраас 2018 онд баталсан “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах” 258 тогтоол, нийслэлээс 2018 оныг “Хариуцлагын жил” болгож, 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасны хугацааны нэмэгдэл олгох журам”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэсэгдэл хөлс олгох журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”, Төрийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-уудын хэрэгжилтийг хангаж, ажиллагаандаа хэвшил болгон ажиллаж ирлээ. Үүнд:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоол, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтуудыг үндэслэн Соёлын Төв Өргөөний “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”, албаны “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам”-ыг баталж, хэрэгжүүлж хэвшлээ.
2. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж, холбогдох заалтыг байгууллагын дотоод

журамд тусгаж хэрэгжүүлж байна. Мөн Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 1.2 дах заалтыг үндэслэн байгууллагын чиг үүрэг, үйлчилгээний онцлогийг харгалзан албан хаагчдын ёс зүйн дүрмийг боловсруулан гаргаж, мөрдөж байна. **2021 онд албан хаагчид ёс зүйн зөрчил гаргаагүй болно.**

3. Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын хэрэгжилтийг хангаж, 2021 онд өндөр насны тэтгэвэрт гарсан 2 албан хаагчид **68,514,312** төгрөгийг, гачигдлын улмаас 6 албан хаагчдын ар гэрт нь **3,300,000** төгрөг, нийт **71,814,312** төгрөгийн буцалтгүй тусламжийг олголоо.
4. “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”-ийн дагуу Захирал, ахлах нягтлан бодогч нар хувийн ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг хуулийн дагуу гаргаж өгсөн.
5. Шилэн дансны хуулийн дагуу 2021 оны жилийн холбогдох санхүүгийн мэдээллүүдийг цаг хугацаанд нь шилэн дансны нэгдсэн системд оруулж ажиллалаа. Энд батлагдсан төсөв сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн харьцуулалт, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээ зэрэг багтаж байгаа юм. Мөн шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллаж, тайланг цаг тухайд нь Сангийн яаманд илгээж байна. 2021 онд нийт 152 шилэн дансны мэдээлэл оруулахаас 2021 онд 152 мэдээлэл байршууллаа.
6. Албан хаагчдын сахилга, үйл ажиллагааны аюулгүй байдлыг 40 камераар байнга хянаж, Ковид-19 цар тахлын үед албан хаагчдын ажилд ирсэн, явсан цагийг ERP цахим системээр бүртгэлжүүлж үйл ажиллагаандаа хэвшүүлсэн болно. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоол, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтуудыг үндэслэн Соёлын Төв Өргөөний “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”, албаны “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам”-ыг баталж, хэрэгжүүлж эхэллээ.
7. Сар шинийн баяр, бүх нийтийн амралтын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийн хуваарийг захирлын тушаалаар томилон ажиллаж, техникийн ямар нэгэн саад гэмтэл, осолгүй хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга бат, гүйцэтгэлийн хариуцлагын талаарх хууль тогтоомжийг мөрдөж, ажиллаж ирлээ.

2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитыг нийслэл дэх Төрийн аудитын газраар хийлгэж, “**Санхүүгийн тайлангаа холбогдох хууль, санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, нягтлан болох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлсэн холбогдох заавар журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн, санхүүгийн зөрчилгүй**” гэсэн дүгнэлт авсан.

2.3 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр дэх Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна (1.1.1), Хотын соёлыг төлөвшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна (2.6.3) зорилтуудыг амжилттай хэрэгжүүлж ирлээ. Хэрэгжилтийг тайлангийн (3.1.2) хэсэгт тодорхой тусгасан болно.

Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн:

3.1. Хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийсэн ажил, үр дүн.

Өргөө нь байгууллагын дүрмээр хүлээсэн “Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан соёл урлагийн бодлого зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, “Нийслэлийн хүн амд соёл урлагаар үйлчлэх үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх” үүргийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарим ажлаа хэрэгжүүлж эхэллээ. Тухайлбал:

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр Урлаг, соёл, спортын арга хэмжээг 50 хувийн дүүргэлттэйгээр зохион байгуулах ажлын хүрээнд Дэлхий дахинд тархсан Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комисс, Эрүүл мэндийн яам, бусад мэргэжлийн байгууллагуудаас гаргасан тогтоол, захирамж, тушаал, заавар, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах “Комиссын бүрэлдэхүүн”-ийг томилж, “Ажлын төлөвлөгөө” гарган, халдвар хамгаалалтын дэглэмийг сахиулж, шаардагдах материалын нөөцийг бүрдүүлж, Соёл урлагийн арга хэмжээнд тавигдах тусгай нөхцөл шаардлага, стандартуудыг мөрдөж ажиллаж эхэллээ.

Мөн Нийслэлийн Соёл Урлагийн газрын дарга Ж.Дамдинцэрэн, СБД-ийн Засаг даргын дэргэдэх “Худалдаа, үйлчилгээ зохицуулах зөвлөл”-ийн дарга, дүүргийн Засаг даргын орлогч Ц.Шижир нартай “Соёл урлагийн үйл ажиллагааны хариуцлагийн гэрээ”-г 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр байгуулж, гэрээнд заагдсан үүргээ биелүүлж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллаж байна.

Коронавируст /ковид-19/ цар тахлын өнөөгийн нөхцөл байдалд Урлагийн тоглолт арга хэмжээ эхэлсэнтэй холбогдуулан **“Их танхим”-ыг ашиглуулах түрээсийн гэрээнд “Хариуцлагын гэрээ”**-ээр хүлээсэн “Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр УОК-оос гаргасан журам, ажлын байранд тавигдаж халдвар хамгаалалтын дэглэмийг сахиулах, үйл ажиллагааг хэвийн явуулах” нэмэлт өөрчлөлт оруулан, хэрэгжүүлж, дараах арга хэмжээг зохион байгуулж, нийт **31** удаагийн тоглолт, хурал, лекцийн арга хэмжээнд **15000 гаруй** хүнд үйлчилсэн байна. Тухайлбал:

- Монгол Ардын намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч У.Хүрэлсүхийн иргэд, сонгогчидтой хийх 2 удаагийн уулзалт,
- Боловсрол Шинжлэх Ухааны яамнаас зохион байгуулсан “Цахим хонхны баяр”-ын ТВ-ийн шууд нэвтрүүлэг
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Монголын ресторан зоогийн газрын холбоо ГҮТББ-ээс хамтран зохион байгуулсан “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч Аж ахуй нэгжүүдтэй “Хариуцлагын гэрээ” байгуулах зөвлөлдөх уулзалт
- 2021 оны 11 дүгээр сарын 04, 05-ны өдөр Монгол Улс, Оросын холбооны улс хооронд дипломат харилцаа тогтоосны 100-н жилийн ойн арга хэмжээний хүрээнд Оросын Холбооны Улсын “Алан” найрал дуу, бүжгийн чуулгын тоглолт
- 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр бизнес эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудтай Хариуцлагын гэрээний талаарх уулзалт
- 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Соёлын Яам, НЗДТГ хамтарсан байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-н зөвлөгөөний анхдугаар арга хэмжээ
- ШШГЕГ 100 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээ
- Үндэсний номын сан 100 жил жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээ,
- Төрийн далбааны өдрийн арга хэмжээ
- Цэргийн Хөгжмийн Коллеж 30 жил
- Нил Цагаан драмын жүжиг
- Байгаль орчны төрийн бус байгууллагуудын үндэсний VII чуулган
- Монголын Бодибилдинг фитнесийн 2021 оны улсын аварга
- Нийслэлийн цагдаагийн газрын 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хурал
- Болор Цом яруу найргийн наадам,
- Нийслэлийн Боловсролын газар

- Эрүүл Мэндийн Яам 100 жилийн ойн хурал, концерт зэргийг тус тус хамтран зохион байгуулж ажиллалаа.









3.1.1. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр дэх /1.1.1/ “Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна”, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр дэх /2.6.3/ “Хотын соёлыг төлөвшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна” зорилтуудын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ.

Манай байгууллага нь Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 18 дугаар тушаал болон 20 дугаар тушаал, Нийслэлийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот хурлын тэмдэглэл, Монгол Улсын Соёлын сайдын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/20 дугаар тушаалуудыг тус тус баримтлан халдвар хамгааллын дэглэмийг өндөр баримтлан нэг чигийн урсгалаар хөдөлгөөнийг давхцуулахгүй байдлаар үзэгчдийн хаалганд орох гарах хөдөлгөөнийг зохицуулах хариуцлагатай жижүүрийг томилон, үзэгч үйлчлүүлэгчдийн халууныг хэмжих багаж хэрэгслийг байршуулж, QR код уншуулах, амны хаалт зүүх, гарыг халдваргүйжүүлэх шаардлага тавьж ажиллалаа.



Тоглолт арга хэмжээг зохион байгуулагч байгууллагад үзвэрийн тасалбарыг цахимаар борлуулах шаардлага тавьж, тоглолтонд оролцож байгаа жүжигчдийг PCR шинжилгээнд хамруулж, халдвар хамгааллын дэглэмийн хүрээнд тоглолт арга хэмжээг зохион байгуулж ажиллах үүрэг өгч хэрэгжилтэд хяналт тавьлаа.

Үзэгчдийн үзвэр үзэх соёлыг нэмэгдүүлж, үзвэрийн танхимд соёлтой үйлчлүүлэх тухай, Коронавируст/Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх суудал хоорондын зайгаа барих, үзвэрийн танхимд маскаа авахгүй байх, халдвар хамгааллын дэглэмээ чанд сахин үйлчлүүлэх талаар тоглолт арга хэмжээ эхлэхийн өмнө “Аудио бичлэг”-ийг үйлчлүүлэгчдэд сонсгон анхааруулж ажиллалаа. Үүнд:

- Үзвэрийн танхимд ус ундаа, хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхийг хориглосон санамжуудыг байршууллаа.
- Тоглолт арга хэмжээний үед тайзны тайзны тоног төхөөрөмжийг ариутгалын бодисоор тогтмол цэвэрлэж, микрофоныг нэг удаагийн бүрхэвч уутаар хамгаалж тогтмол сольж халдвар хамгааллын дэглэмийг сахиж ажиллалаа.
- Их танхимд үзвэрийн өмнө ба дараа агаар сэлгэлт тогтмол хийж, цэвэрлэгээ үйлчилгээг халдваргүйжүүлэх бодис уусмал ашиглан халдвар хамгааллын дэглэмийг сахин чанартай гүйцэтгэлээ.



- Нийслэлийн Соёл Урлагийн газрын дарга Ж.Дамдинцэрэн, СБД-ийн Засаг даргын дэргэдэх “Худалдаа, үйлчилгээ зохицуулах зөвлөл”-ийн дарга, дүүргийн Засаг даргын орлогч Ц.Шижир нартай “Соёл урлагийн үйл

ажиллагааны хариуцлагийн гэрээ”-г 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр байгуулж, гэрээнд заагдсан үүргээ биелүүлэн халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллаж, тоглолт арга хэмжээнд ирсэн нэмэлт III тунд хамрагдаагүй иргэдээс “Түргэвчилсэн шинжилгээ” авах өрөөг бэлтгэн тохижуулж ажиллалаа.



- Ковид-19 цар тахлаас сэргийлэх, халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ажиллах комиссын бүрэлдэхүүнийг томилж, байгууллагын “А”, “Г” зонд **“Түр тусгаарлах өрөө”**-г гаргаж шаардлагатай тоног төхөөрөмж, ариун цэвэр эрүүл ахуйн хэрэгслүүдээр ханган бэлэн байдалд ажиллаж байна. Түр тусгаарлах өрөөнд ор, ширээ сандал, ус буцалгагч, нэг удаагийн аяга, гарын цаасан алчуур, 00 цаас, гарын шингэн саван, гар халдваргүйжүүлэх уусмал, зэргээр бүрэн хангаж ажиллалаа. Нийслэлийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн заавар зөвлөмж, сэжигтэй тохиолдол илэрсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох бүх ажилтан албан хаагчдад танилцуулж шаардлагатай мэдээллийг өгч ажиллалаа.



ЭМЯ болон мэргэжлийн байгууллагуудаас өгч буй халдвараас хамгаалах заавар зөвлөмжийг хэвлэж, шаардлагатай хэсгүүдэд байршууллаа. Хамт олныг бөөгнөрөл үүсгэхгүйгээр, хүн хоорондын зай барихыг зөвлөж, амны хаалт зүүж хэвшлээ.


UB ERP-EDoc системийг ашиглан цахим тоон гарын үсгээр албан бичгүүдээ илгээж, хүлээн авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын албан ёсны вебсайтад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас болон УОК, НОК, ЭМЯ-аас өгч байгаа зөвлөмж, шаардлагыг тогтмол нийтэлж, “Маскаа зүүе, гараа угаая” аяны талаар тогтмол сурталчилж ажиллаж байна.



Ковид-19 цар тахалтай холбоотойгоор байгууллагын “А” болон “Г” хэсэгт албан хаагч иргэн, үйлчлүүлэгчийн орох хөдөлгөөнд хяналт тавих “Хариуцлагатай жижүүр”-ийг томилон ажиллуулж, шаардлагатай тоног төхөөрөмж болох хүний оролцоогүйгээр биеийн халууныг хэмжих боломжтой “Халуун хэмжигч”-ийг 2 хэсэгт

байршуулж, гар ариутгагч, нүүрний хаалт, маск, нэг удаагийн хамгаалалтын бээлийгээр ханган ажиллаж хэвшлээ.

Үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, албан хаагч болон дотогш нэвтэрч байгаа хүний биеийн халууныг тогтмол хэмжиж, халдвар хамгааллын дэглэм баримтлуулан амны хаалт зүүх шаардлага тавьж, гар ариутгах, халдваргүйтгэх нөхцөлөөр бүрэн ханган ажиллаж байна. Байгууллага аж ахуйн нэгжээр үйлчлүүлэхээр ирсэн иргэд, үйлчлүүлэгчдэд болон ажиллагсдад QR код уншуулах, амны хаалт зүүх шаардлага тавьж, хүн хоорондын 1,5 метрийн зайг барьж бөөгнөрөл үүсгэхгүйгээр үйлчлүүлэхэд анхаарч ажиллаж байна.




- Нийслэлийн Соёлын Төв Өргөө нь Ковид-19 /коронавируст/ халдварын цар тахлаас урьдчилан сэргийлж урьдчилан сэргийлэх тархалт хүрээг нь нэмэгдүүлэхгүйн тулд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай хамтран ариутгал халдваргүйжүүлэлтийг цаг тухай бүрт нь хийж гүйцэтгүүлж ажиллаж байна.

2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр болон 03-р сарын 08-ний өдрүүдэд “Түвшинбилэг төгөлдөр” ХХК-аар байгууллагын “А” хэсгийн үзэгч, ажиллагсадын орох хаалга болон их танхимын тайз, партер, бельэтаж, жүжигчдийн өрөө, 00-ын өрөө, визитны өрөө, коридор, фойе зэрэг бүхий л хэсгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгүүлээ.



Байгууллагын “А” болон “Г” хэсгийн үүдний хүлээлгийн хэсэг, коридор, 1-12 давхрын явган хүний шат, оффисын өрөө, лифтний холл, лифт, фойей, 00-ын өрөө зэрэг хэсгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийг 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдөр “Түвшинбилэг төгөлдөр” ХХК-аар хийж гүйцэтгүүлж ажиллалаа.





Байгууллагын “А” болон “Г” хэсгийн коридор фойе, их танхим, 00-ын өрөө, лифтний холл, үүдний хүлээлгийн хэсгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийг 2021 оны 05 дугаар сарын 25, 27-ны өдрүүдэд нийт 3 удаагийн давтамжтайгаар “Цасны хачир” ХХК-аар хийж гүйцэтгүүллээ.





Байгууллагын “А” хэсгийн их танхим, коридор, фойе, ажилчдын өрөө зэрэг хэсгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр “Түвшинбилэг төгөлдөр” ХХК-аар хийж гүйцэтгүүллээ.



Цар тахлаас урьдчилан сэргийлэх, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж, дэгдэлтийг нэмэгдүүлэхгүйн тулд байгууллагад мананцар үүсгэгч автомат төхөөрөмжийг авч ажиллуулж, “А” болон “Г” хэсгийн үүдний хүлээлгийн өрөө, 00-ын өрөө, лифт, лифтний холл, коридор болон түрээслэгч байгууллагуудад тухай бүрт нь ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажиллаж байна.



Байгууллагын “А” хэсгийн их танхим, коридор, фойе, ажилчдын өрөө зэрэг хэсгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр “Түвшинбилэг төгөлдөр” ХХК-аар хийж гүйцэтгүүлээ. Мөн цар тахлаас урьдчилан сэргийлж мананцар үүсгэгч автомат төхөөрөмж авч, түрээслэгч байгууллагуудад болон шаардлагатай хэсгүүдэд өдөр тутамд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажиллаж байна. Байгууллагын хэмжээнд ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх ажлыг нийт 10 удаа зохион байгуулж, Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

- Ковид-19 цар тахлын үед үйлчлэгч нар өөрсдийн хариуцсан талбайдаа өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг зориулалтын ариутгалын бодисоор хийхээс гадна үзэгчдийн их танхимын хивсэнцэр, 3-р давхрын фойены хивсэнцэрийн өнгөлгөө, “А”, “Г” байрны подвалд бүх нийтийн их цэвэрлэгээг 14 хоногт 1 удаа тогтмол хийж, өрөө тасалгаанд ариутгалын бодистой цэвэрлэгээг өдөрт 2 удаа хийж, шат хаалганы бариул зэрэг хүн их хүрдэг хэсгийг ариутгалын бодистой уусмалаар байнга арчиж, цэвэрлэж байна.
- Улсын Онцгой комиссын Шуурхай штабаас 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 10685 дугаартай албан бичгээр Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын III тунгийн хамрагдалтын нэмэгдүүлэх чиглэлийн дагуу Нийслэлийн хэмжээнд Коронавируст /Ковид-19/-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунгаар вакцинжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөө гарсантай холбогдуулан Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв эмнэлэгтэй хамтран байгууллагын 30 ажилтан албан хаагчдыг III тунд хамруулж ажиллалаа. Байгууллагын хэмжээнд 37 албан хаагч буюу 71%-тай нэмэлт тунд хамрагдаж, үлдсэн нэмэлт тунд хамрагдаагүй 13 албан хаагч

байгаагаас эрүүл мэндийн шалтгаантай 8 албан хаагч, халдвар аваад эдгэрээд 21 хоног болоогүй байгаа 5 албан хаагчид байна. Дархлаажуулалтад хамрагдсан албан хаагчдын өдөр тутмын тоон мэдээг НОК-ын холбогдох и-мэйл хаягруу мэдээллэж ажиллаж байна.



Засгийн газар, Улсын болон нийслэлийн онцгой комисс, Нийслэлийн Засаг даргаас гаргасан шийдвэрээр “Улсын хэмжээнд өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын дэглэм тогтоож, соёл урлаг, олон нийтийн үйл ажиллагааг зогсоосон нь хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтоо бүрэн хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж зорилтот түвшинд хүрч ажиллаагүй.

3.2. **Байгуулагын менежментийг боловсронгуй болгох, өмчийн ашиглалтыг сайжруулах талаар:**

Өргөө нь байгууллагын дүрмээр хүлээсэн “Нийслэлийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад түрээслүүлэх” үүргээ хангалттай хэрэгжүүлж ажиллаж байна. Тухайлбал:

Өргөөний цогцолборын дулаан, цахилгаан, ус хангамжийн болон хог хаягдал, лифтийн үйлчилгээний аж ахуйн гэрээг байгуулж, найдвартай ажиллагааг

хангаж, өвлийн халаалтын дулаан, сантехник, цахилгаан, усан хангамжийн ямар нэгэн доголдол, аваар осолгүй ажилласан болно.


Цахилгаан эрчим хүчний гэрээг 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай, дулааны эрчим хүчийг худалдах, худалдан авах гэрээг 2028 оны 10 дугаар сарын 01 хүртэл 4 жилийн хугацаатай тус тус сунгалаа.

Түрээслэгч байгууллагуудаас 2021 онд ирсэн санал хүсэлтийг хугацаанд нь барагдуулж, 4 дүгээр сарын 1-нд салхивч, 5 дугаар сарын 1-нд халаалтаа хааж, засварын ажлуудыг хийж ажиллалаа. Инженер техникийн алба шаардлагатай багаж техник хэрэгсэл, урсгал засварыг батлагдсан төсөвт багтаан хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр “А” хэсгийн хүйтэн усны эргэлтийн шугам цоорсоныг засаж, хэвийн ажиллах нөхцөлийг ханган ажиллалаа



2. “Г” хэсгийн 10-р давхрын хойд болон урд жигүүрийн 00-ын уян холбоос сэтэрч, задарсаныг шинээр сольж, хэвийн ажиллагаанд оруулж ажиллалаа.



3. “А” хэсгийн 306,307 тоот өрөөнүүдийг “Ажиллагсадын цайны өрөө”-ний зориулалтаар засварлаж, тохижууллаа. Үүнд: хана, таазыг хусаж цэвэрлэх, гипсэн хавтангаар уналттай тааз хийж хүрээ булан тогтоон, фүжи шин

цаасан обойг таазанд нааж, хананд грунд түрхэж хоёр хэсэг хананд дулаан хадгалах гоёлын хөөсөнцөр хийж тохижууллаа.



4. Байгууллагын өвлийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд сантехникийн шугам сүлжээний найдвартай ажиллагааг шалгаж, эргэлтийн хүйтэн усны шугам элэгдэлд орж, үйл ажиллагаа доголдоход хүрснийг тогтоож, яаралтай арга хэмжээ авч, засвар хийлээ. Тус цогцолбор барилга ашиглалтад орсноос хойш эргэлтийн хүйтэн усны шугам сүлжээнд их засвар хийгдээгүйгээс хүйтэн усны хоолойд элэгдэл үүсч, олон газраар цоорон ус шүүрж, задарсан 152 метр хоолойг өөрсдийн хүчээр сольж, шинээр тавилаа. Ингэснээр цэвэр усны алдагдлыг бууруулж, зардлаа хэмнэж, өвлийн бэлтгэлийг хангаж ажиллалаа.

Мөн бохирын шугамын гаднах 21 худгийг лайдаж цэвэрлэв.

Цэвэр усны хуучин хоолойн зураг







5. Дулааны эрчим хүчийг тооцох хэмжих хэрэгсэл болох Дани улсад үйлдвэрлэгдсэн Камstrup фирмийн Мультикал 603 загварын хэт авианы дулааны тоолуурыг ИКОН ХХК-тай худалдах худалдан авах гэрээний дагуу худалдан авч, уг компаниар суурилуулан дулааны найдвартай тооцоолууртай боллоо.



6. “А” хэсгийн дээвэрт гардаг хаалгыг шинэчилж, “Г” хэсгийн 5-р давхрын урд талын балконы хаалганы мембран хууларсныг ирмэгээр нь төмөр бэхэлж бороо цасны ус дотогшоо алдахаас хамгааллаа.



7. Коронавируст/ковид-19/ цар тахлын үед байгууллагын ажиллагсадын бие бялдар эрүүл мэнд, дархлааг дэмжиж биеийн тамир спортоор чийрэгжүүлж хөгжүүлэхийн тулд "А" зоны подвалийн хэсэгт "Фитнесийн өрөө"-г засаж тохижуулахаар засвар үйлчилгээг хийж ажиллаж байна.



8. Техникийн давхарт усны хаялганы хоолой хөлдөж, задран ус гоожиж байсныг силконоор битүүлж хэвийн ажиллагаанд нь оруулж ажиллалаа.



9. "А" хэсгийн үзэгчдийн ариун цэврийн өрөөний дулааны шугам цоорч ус алдсаны улмаас нурж унасныг шинээр гипсэн тааз хийж, замаска тавин, эмульсдэн будаж аюулгүй ажиллагааг хангаж ажиллалаа.



10. “А” хэсгийн визитны бэлтгэлийн өрөөний тааз хэрэглээний шугам цоорч ус алдаж унасныг тогтоож замаска, эмульс хийж засч ажиллалаа.



11. “Г” зоны 8-р давхрын урд хэсэгт бохирын холболт гэмтсэнийг 50ф хоолойг сольж аюулгүй найдвартай ажиллагааг хангаж, өвлийн халаалтын дулаан, сантехник, цахилгаан, усан хангамжийн ямар нэгэн доголдол, аваар осолгүй ажиллалаа.



12. Дээврийн болон цасны хог хаягдлыг тухай бүрт нь цэвэрлэж хэвшүүлээ.




13. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс хүн зөөврийн 4 лифтэнд гар ариутгалын шингэнийг зориулалтын саванд хийж байршуулав.



14. Нийслэл дэх Төрийн Аудитын газрын V давхрын коридорын таазны хагарсан хэсэгт кнап татаж эмульсээр будаж засвар хийж ажиллалаа.



15. Г хэсгийн 6-р давхрын Бурхан халдун тахилгат уулын газрын 4 ширхэг вакум цонхны амалгааг гипсэн хавтангаар таглаж, давхар хөөсөөр дулаалга хийснээр дулаан алдалтыг бууруулж, ажиллах нөхцлийг сайжруулж ажиллалаа.



16. А хэсгийн нийтийн 00-ын өрөө, тамхины өрөөний таазыг эмульсээр шинэчилж будав. Мөн таазны гэрэлтүүлгийг нэмж суурьлууллаа.





17. 7-р давхарт байрлах Нүүдлийн Соёл иргэншлийн үндэсний төвийн ариун цэврийн өрөөг шинэчлэхээр туслах ханыг нурааж өрөөг томсгон шалыг плитадаж засвар хийж шинэчлэлээ.
18. А хэсгийн 216 тоот өрөөний 6 цонхонд жалюзан хөшиг авч тогтоож, жижүүрийн хэсгийн байрлалыг сольж цэгцлэн, жижүүрийн амралтын өрөөг тохижуулав.



19. Инженер техникийн алба нь өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд "Г" зоны 3 давхарт 16 ширхэг халаалтын радиаторыг шинээр суурилуулав. Шинээр суурилуулахтай холбоотойгоор хуучин шугамыг гагнуур хийн таслаж, пластмасан хоолойгоор сольж шугам бүрд хаалт тавин аюулгүй ажиллагааг хангаж, хуучин радиаторуудын салгаж авсан хэсгүүдэд замаска татан, эмульсээр будаж шинэ хаалт хийн ховхорсон шалыг цементээр тэгшлэж ажиллалаа.
20. Нийслэлийн халамжийн газрын тогтоогч нь унасан радиаторыг хааж, тогтоогчийг суурилуулав.
21. Хүүхдийн төв номын сангийн угаалтуур болон холигчийг шинэчилж сольлоо.
22. Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар пар цоорч, цоорсон радиаторыг салгаж шинээр суурилууллаа.

23. Нийслэл дэх Төрийн аудитын газрын засвар хийсэн 4 давхарын өрөөнүүдэд болон 5 давхрын 524 тоотод шинээр радиатор суурилуулж, 4-р давхрын засвар хийсэн 00-ын өрөөний угаалтуур, суултуурыг шинэчлэн суурилуулж ажиллалаа.
24. Нийслэл дэх Төрийн Аудитын газрын 429 тоот өрөөний таазыг эмүльдэн, шалыг паркетлан шалны хүрээ буланг хийж засварлалаа.



25. Нийслэл дэх Төрийн аудитын газрын 6 давхарт байрлах 00-ын өрөөний сангийн холболтыг хийж, угаалтуур,суултуурыг тавьж, 00-ын өрөөг хэвийн ажиллагаанд орууллаа.
26. Улсын Филармоний халахгүй байсан радиаторыг сольж, шинэчлэн суурилуулав. Мөн үүдний хэсгийн салхивчийн хаалтыг авч битүү парнетыг онгойлгов.
27. “А” хэсгийн ажилчдын хаалганы хоёр талд байрлах шатны хаалтны будаг бороо цасны ус чийгэнд халцран унасныг шавардаж ,замасқдан эмүльсээр будаж , мөн эргэн тойрны хаяавч чулуу эмтэрч хагарсныг шинээр чулуу зүсэн тааруулж селиконоор бэхэлж тогтоов.





28. Захирлын өрөө болон нарийн бичгийн өрөө, коридорийн таазыг эмүльдэж шатсан гэрлүүдийг сольж, угаагуурын холигчийг шинээр сольж ажилууллаа.



29. Сити центрийн урд байрлах бохирын хоолой бөглөрснийг УСУГ-тай хамтран зориулалтын троссоор бөглөөсийг гаргуулж аюулгүй ажиллагааг хангаж ажиллалаа.



30. Барилгын суурийн хэсэгт хөрсний ус соруулдаг гном шатсаныг шинээр авж холбон суурилуулж , аюулгүй ажиллагааг хангалаа.



31. Үзэгчдэд тав тухтай үйлчилгээ үзүүлэх үүднээс их танхимын дулааныг нэмэгдүүлэхэд анхаарч 380Вт-ийн цахилгааны самбарт шинээр 50 амперийн 4 ширхэг, 100 амперийн 1 ширхэг автоматтуудыг шинээр суурилуулж, подвальд байрлах цахилгааны ерөнхий шугамнаас 4x16 зэс

голчтой 52м кабелийг их танхим хүртэл дотуур монтаж хийн татаж, зрителийн баруун талд 1700м² халаах чадал бүхий халуун үлээгчийг холбож ая тухтай байдлыг хангаж ажиллалаа.

32. Үзэгчдийн их танхимын зүүн талд байрлах дулаан салхин хөшигт нэмэлт автомат нэмж байрлуулж ажиллалаа.

33. Үзэгчдийн төв хаалганы дээд талд халуун үлээгч ажиллуулахын тулд цахилгааны төв шугаманд 100 амперийн автомат нэмж суурилуулан 4х10 голчтой 20м зэс кабель татаж холболоо . Энэ нь хүйтний улиралд ковидын нөхцөл байдалтай холбоотойгоор үүдний хэсэгт үзэгчдийн халуун хэмжих, дархлаажуулалтын III тунг шалгах үед үзэгчид болон ажиллагсад даарах, ханиад томуу хүрэх эрсдлээс хамгаалж байна.

3.3. Төсвийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтийн тухай.

Манай байгууллага түрээсийн буюу үзвэр үйлчилгээ, арга хэмжээний орлогоор үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, батлагдсан төсөв, үр дүнгийн гэрээний хүрээнд зардал гарган, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, хуулийн хугацаанд тайлагнаж ирлээ.

2021 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нийлсэн **39** түрээслэгчтэй түрээсийн гэрээ байгуулан, гэрээний биелэлтийг хангуулж, НИТХ-аас баталсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлж, төсвийн сахилгыг чанд сахиж ажиллалаа.

Орлого буурч, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогыг дутуу төвлөрүүлсэн нь “Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийслэлийн иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах” тухай Засгийн газар, Улсын болон Нийслэлийн онцгой комисс, Нийслэлийн Засаг даргаас гаргасан шийдвэрээр “Улсын хэмжээнд Бүх нийтийн бэлэн байдал болон өндөржүүлсэн бэлэн байдал тогтоож, соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарласантай холбоотой юм.

Нийслэлийн Соёлын Төв Өргөөний 2000-2021 онд бүрдүүлсэн орлого, төсөвт төвлөрүүлсэн, үйл ажиллагааг санхүүжүүлсэн мөнгөн хөрөнгийн тооцоо

Д/д	Он	Нийт бүрдүүлсэн орлого /мян.төг/	Зарлага		Захирамжаар /мян.төг/	Төвлөрү үлэх орлогын төлөвлөгөө /мян.төг/	Хувь
			Зардал санхүүжүүлэх /мян.төг/	Төвлөрүүлсэн орлого /мян.төг/			
1	2000	565,261.6	376666.6	188595		171419.7	110
2	2001	789,100.5	576733	212367.5	10,500.00	176391.7	120.4
3	2002	730,734.7	544884.7	185850	16,950.00	185524.8	105.3
4	2003	704,033.9	496433.9	207600	43,000.00	206400	105.6
5	2004	983,306.7	708514.7	274792	24,050.00	210993.7	135.4
6	2005	1,120,315.8	856616.4	263699.4	87,150.00	263699.4	106.4
7	2006	1,287,005.2	929403.2	357602	98,350.00	345291.8	103.6
8	2007	1,513,564.6	1050507.7	463056.9	6,225.00	375009.6	171.5
9	2008	1,464,915.5	1100407.2	364508.2	50,750.00	364449.2	100
10	2009	1,267,699.4	1017699.4	250000	74,400.00	249340.6	100.3
11	2010	1,388,227.8	1108227.8	280000	88,750.00	280006.2	100
12	2011	1,552,116.9	1239008.6	298428.8	78,575.00	298428.8	100
13	2012	1,694,306.2	1782669.5	450000	44,162.50	304031.9	148
14	2013	1,637,720.6	1372057	380000	147,500.00	377545.2	100.7
15	2014	1,659,664.5	1252664.4	407000	104,500.00	406027.6	100.2
16	2015	1,580,607.1	1157707.1	422900	89,500.00	422000	100.2
17	2016	1,564,740.4	1202740.4	362000	102000	361093.7	100.3
18	2017	1,476,899.4	1109974.5	361247.8	161500	361247.8	100
19	2018	1,396,156.0	1070462.3	325693.7	168500	325193.2	100
20	2019	1,665,383.4	1319455.6	332000	295000	332000	100.2
21	2020	963,758.1	1078049.2	24933.9	49000	0	
22	2021	1,222,439.7	1113133.7	109306.1	112750.0	151696.7	
	Дүн	28,227,958	22,464,017	6,521,581	1,853,113	6,167,792	



3.4. Албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар дараах ажлуудыг хийлээ.

Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, сургалтад хамруулах, ажиллах нөхцлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоол, Засгийн газраас 2018 онд баталсан “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах” 258 тогтоол, нийслэлээс 2018 оныг “Хариуцлагын жил” болгож, 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасны хугацааны нэмэгдэл олгох журам”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэсэгдэл хөлс олгох журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”, Төрийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-уудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Мөн албан хаагчдын эрүүл мэнд, ажлын байрны нөхцөл сайжруулах, сургах, мэргэшүүлэх, үйлчилгээ, харилцааны соёл эзэмшүүлэх, хүний нөөцийн судалгаа, албан хаагчдын хувийг хэргийг жил бүр шинэчлэн өөрчлөх, бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, зэрэг олон ажлыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжүүлж хэвшлээ. Тухайлбал:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 04 дүгээр хавсралтын дагуу албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасан зорилтын биелэлтийг дараах чиглэлээр тооцон гаргалаа. (Хавсралт хүснэгтээс үзнэ үү)

Хүний нөөцийг хөгжүүлэх идэвхжүүлэх чиглэлээр:

1.1. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхээр зохион байгуулсан сургалтад нийт 23 чиглэлийн сургалт, зөвлөгөөнд 46 албан хаагч (давхардсан тоогоор) хамрагдлаа. Үүнээс туршлага солилцох зөвлөгөөнд 7 олноороо оролцож, бусад сургалтад 16 албан хаагч оролцсоны 9 нь эмэгтэй, 7 нь эрэгтэй, 5 удирдах ажилтан, 11 нь гүйцэтгэх, туслах ажилтан байна. Сургалт, семинар, зөвлөгөөнд хамрагсдын тоо нийт албан хаагчдын 95%-ийг эзэлж байна.

Мэргэших чиглэлээр захирал Д.Ариунбаатар “Хүний нөөцийн удирлага” сургалтад, ахлах нягтлан бодогч Ө.Цолмон, тооцооны нягтлан бодогч Д.Гэрэлтуяа нар Мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтад суралцлаа. Улмаар ахлах нягтлан

бодогч Ө.Цолмон мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтад орж, тэнцэж, Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч боллоо. (Сургалтад хамрагдсан дэлгэрэнгүй тайланг хавсралтаар үзүүлэв)

3.3.1.1. **Албан хаагчдыг байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр гадаад сургалтад хамруулаагүй.** Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах зорилгоор Улсын хэмжээнд Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, улмаар соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг хязгаарласан нь зарим албан хаагчдыг хамруулах ёстой ажлын байрны, ганцаарчилсан сургалтыг явуулж чадаагүй байна.

3.3.1.2. **Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт, хөдөлгөөнийг авч үзэхэд**

- Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэхэд 640.0 мянган төгрөг зарцууллаа. Өөрсдийн зардлаар Мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтад Ахлах нягтлан бодогч Ө.Цолмон, тооцооны нягтлан бодогч Д.Гэрэлтуяа нар өөрсдийн зардлаар сурсан болно. Ахлах нягтлан бодогч Ө.Цолмон Мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтад амжилттай тэнцэж, үнэмлэхээ гардан авлаа.
- Албан хаагчдыг томилсон, чөлөөлсөн хөдөлгөөн тайлангаар 2021 онын 01 дүгээр сарын 01-нд нийт 50 албан хаагч ажиллаж байсан бол 2022 онын 01 дүгээр сарын 01-ний байдлаар 48 албан хаагч ажиллаж байна. Энэ хугацаанд Нийслэлийн Засаг даргын захирамжаар Д.Ариунбаатар захирал томилогдож, Б.Байгалмаа захирал чөлөөлөгдсөн.
- Албан тушаалын тодорхойлолтын шаардлагыг хангасан архив, бичиг хэргийн ажилтан, жолооч, сантехникийн ээлжийн диспетчер, үйлчлэгч, ээлжийн жижүүр нарын 11 иргэнийг ажилд томилж, 13 албан хаагч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн байна.

3.3.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

3.3.2.1. **Албан хаагчдын цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэхэд** цалинд **359826.5** мянган төгрөгийг, төрийн алба хаасны нэмэгдэлд **25292.6** мянган төгрөгийг, ур чадварын нэмэгдэлд **21693.4** мянган төгрөгийг, хоол унаанд **61769.0** мянган төгрөгийг, хавсран ажилласны хөлсөнд **31103.2** мянган төгрөгийг, үр дүнгийн урамшуулалд **60734.3** мянган төгрөгийг, професорын нэмэгдэлд **785.2** мянган төгрөгийг, нийт **561204.2** мянган төгрөгийг зарцуулсан байна. Ахлах

нягтлан бодогч Ө.Цолмон “Санхүү, банкны тэргүүний ажилтан” цолоор шагналдаа.



3.3.2.2. Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр хамт олноос санал авч, дараах ажлуудыг хийлээ.

- Албан хаагчдыг тав тухтай орчинд хооллох, эрүүл чанартай хүнсээр өдрийн хоол цайгаа бэлтгэх нөхцөлийг бүрдүүлж, “А” хэсгийн 306, 307 тоот өрөөнүүдийг амралтын цайны өрөө болгон тохижууллаа. Үүнд: Хана таазанд замаска, кнап татан зүлгүүрдэж эмульсээр будаж, таазыг орчин үеийн уналттай тааз хийн, ирмэг, булан, хүрээ хадаж, хананд 3 ди хөөсөнцөр хавтан болон фужи шин обой нааж, ирмэгээр нь гоёлын булан гарган эмжүүлж, модон хаалга суулгав. Амралтын өрөөнд шинээр гал тогооны ком, хөргөгч, плитка, шарах шүүгээ, хөлдөөгч зэргийг суурилуулж, хүнсний материалаа хадгалах боломжоор хангаж өглөө.
- Албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах, Коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, үйлчлүүлэгчид болон түрээслэгчдийн ажлын байрны аюулгүй байдлыг хангаж болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын дэргэдэх Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн үйл ажиллагаанд шаардлагатай компьютерийн дэлгэц/монитор/, иж бүрэн компьютер, нөүтбүүк, принтер, байгууллагын “А” зоны их танхимын партер, бельэтаж руу харах чиглэлд, ВИП өрөө, үйлчлүүлэгчдийн болон ажиллагсадын орох, гарах хаалганы чиглэлд гадна болон дотор талд шөнийн хараатай, 5 мегапиксел нягтаршилтай 6 камер нэмэлтээр байршуулж, “Г” зоны үүдний хэсэгт нэмэлтээр 2 камер болон дэлгэц, NVR бичигч, хатуу диск, холбох хэрэгслүүдийг Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газраас зохих журмын дагуу зөвшөөрлөөр худалдан авч ажиллалаа.

3.3.2.3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр

- 2021 оны жилийн эцсийн байдлаар байдлаар байгууллагын нийт ажилтан албан хаагчид урьдчилан сэргийлэх вакцины I, II тунд бүрэн хамрагдсан бөгөөд вакцины III тунд нийт 45 ажилтнаас 38 ажилтан хамрагдаж, эрүүл мэндийн шалтгаантай бөгөөд Ковид-19 цар тахлаар өвдөөд 21 хоноогүй 7 ажилтан вакцины III тунд хамрагдаагүй байна. Вакцины III тунгийн хамрагдалт 84,4%-тай байна.
- Байгууллагын ажиллагсад болон түрээслэгч байгууллагуудын ажилтан албан хаагчдын нийт 102 хүнийг коронавируст /ковид-19/ цар тахлын вирус илрүүлэх шинжилгээнд хамруулж, вируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажилласан.
- Нийслэлийн Засаг Даргын тамгын газраас зохион байгуулсан Нийслэлийн харъяа нутгийн захиргааны байгууллагуудын ажиллагсадыг 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр коронавируст /ковид-19/ цар тахлын вирус илрүүлэх шинжилгээнд хамруулсан бөгөөд уг шинжилгээнд нийт ажилтнуудаа хамрууллаа.
- “Эрүүл мэндийн цахим гүйлт 2021” биеийн тамирын үйл ажиллагааны талаарх мэдээллийг нийт албан хаагчдад танилцуулж мэдээллэсэн бөгөөд байгууллагынхаа 5 албан хаагчдыг STRAVA App-ыг ашиглаж, явган аялалд идэвхитэй хамруулж ажиллалаа.
- Нийслэлийн Засаг Даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийг биеийн тамир, идэвхитэй хөдөлгөөнийг энгийн дасгал болох алхалт гүйлтээр хичээллэхэд уриалах, бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл зөв амьдралын дадал хэвшилд сургах зорилгоор Улсын хэмжээнд биеийн дархлааг дэмжих “Эрүүл мэндийн цахим гүйлт 2021” биеийн тамирын үйл ажиллагааг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос 2021 оны 03 дугаар сарын 15-28-ны өдрүүдэд зохион байгуулагдах тухай удирдамж ирсэний дагуу байгууллагынхаа албан хаагчдыг уг арга хэмжээнд хамрууллаа.

Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах зорилгоор Улсын хэмжээнд Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, улмаар соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг хязгаарласнаас албан хаагчдаа 2021 онд эрүүл мэндийн үзлэг, төрөлжсөн багц шинжилгээнд хамруулаагүй.

3.3.2.4. Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал. Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид

өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын хэрэгжилтийг хангаж, 2021 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 2 албан хаагчид **68,514,312** төгрөг, гачигдлын улмаас 6 албан хаагчдын ар гэрт **10,000,000** төгрөгийн төгрөгийн буцалтгүй тусламж, нийт **78,514,312** төгрөгийг зарцуулсан байна.

3.3.3. Албан хаагчдын ажлын сахилга, хариуцлагыг сайжруулах, ил тод байдлыг хангах чиглэлээр.

- Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах, холбогдох заалтыг байгууллагын дотоод журамд тусгаж хэрэгжүүлж байна. Мөн Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 1.2 дах заалтыг үндэслэн байгууллагын чиг үүрэг, үйлчилгээний онцлогийг харгалзан албан хаагчдын ёс зүйн дүрмийг боловсруулан гаргаж, мөрдөж ажиллаж байна. 2021 оны албан хаагчдаас ёс зүйн зөрчил гаргаагүй болно.
- Албан хаагчдын сахилга, үйл ажиллагааны аюулгүй байдлыг 40 камераар байнга хянаж, албан хаагчдын ажилд ирсэн, явсан цагийг хурууны хээгээр бүртгэж үйл ажиллагаандаа хэвшүүлсэн болно.
- Ажлын байрны сул орон тооны зар, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, албан хаагчдын ёс зүйн дүрэм, “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”, албаны “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам”-ыг цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан байдаг.
- Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг албадын үйл ажиллагааны онцлогийг харгалзан, албадын ажлын тайланг алба, нэгж бүрээр захирлын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж, ажлын гүйцэтгэлийг нь дүгнэж, хэвшсэн. Улмаар албадын үйл ажиллагааны чиглэлээр нийт ажилчдын саналыг сонсож, сүүлийн хагас жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

3.5 Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн талаар дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

www.edoc.ulaanbaatar.mn-ийг ашиглан:

Нийслэлийн байгууллагуудад иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг шийдвэрлэхэд ашиглагдаж буй www.edoc.ub.gov.mn цахим программаар:

Ирсэн албан бичиг: Тайлант хугацаанд нийт 180 албан бичиг ирсэнээс 60 хариутай бичгийг хүлээн авч тухай бүрд нь холбогдох албан тушаалтанд танилцуулж хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь явуулсан.

Явуулсан албан бичиг: Тайлант хугацаанд нийт 121 албан бичиг явуулсан. Үүнээс 16 хариутай бичиг, 105 хариугүй албан бичгийг тус тус явуулсан.

www.erp.ulaanbaatar.mn-ийг ашиглан:

Өргөдөл гомдол: Ажилтнуудаас хандсан өргөдөл гомдол нийт 32-г хүлээн авснаас ажилд орох хүсэлт 16, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт 16-г хүлээн авсан.

Тушаал: “Б” тушаал 68 гарснаас үүнээс ажлаас чөлөөлөх 13, 16 ажилд авах 12, 16 нэмэгдэл цалин олгох тухай 11, буцалтгүй тусламж олгох 7, ээлжийн амралт эдлүүлэх 15 тушаал гарсан байна. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой “А” тушаал 30 гаргаж, хэрэгжүүлсэн байна.

Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал.

4.1. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, төсвийн хөрөнгийн батлагдсан төлөвлөгөө, зарцуулалтын сар улирлын мэдээ, тайлан балансыг цахимаар Нийслэлийн төрийн санд өгч, шилэн дансанд тухай бүр байршуулж, байгууллагын сайтад тавьж нийтэд толилуулж ирлээ.

Мөн түрээсийн буюу үзвэр үйлчилгээ, арга хэмжээний орлогоор үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, батлагдсан төсөв, үр дүнгийн гэрээний хүрээнд зардал гарган, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, хуулийн хугацаанд тайлагнаж хэвшлээ.

4.2. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, дараах ажлуудыг хийж, хэвшүүлээ.

4.2.1. Нийслэлийн Засаг даргын “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2012 оны А/606 дугаар захирамжийн дагуу байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг цаг тухайд нь цахим сайтад байршуулан, ил тод байдлыг хангаж ажиллаж ирлээ.

Мөн цаг үеийн мэдээллийн самбарыг ажилд оруулж өдөр тутмын ажил, тоглолтын график, ажлын дуудлага байрлуулж өдөр, тутмын шинэ мэдээ мэдээллээр хангаж, байгууллагын сайтыг тогтмол ажиллуулж хэвшүүлээ.

4.2.2. Үйлчилгээний ажлын ил тод байдлыг хангах зорилгоор санал, хүсэлт, сэтгэгдлийг нийтийн ариун цэвэр, угтах үйлчилгээ, үйлчилгээний ажилтны харилцааны соёлын чиглэлээр сэтгэл ханамжийн асуулгыг цахимаар болон 6 чиглэлийн асуулга хуудсаар авч хэвшүүлээ.

4.2.3. Албан хаагчдын сахилга, үйл ажиллагааны аюулгүй байдлыг 40 камераар байнга хянаж, Ковид-19 цар тахлын үед албан хаагчдын ажилд ирсэн, явсан цагийг ERP цахим системээр бүртгэлжүүлж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллалаа.

4.3 Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангаж дараах ажлуудыг хийлээ.

- 4.3.1. Албан хаагчдын ёс зүйн дүрмийг болон ажлын байрны сул орон тооны зарыг цахим хуудас, мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулж, тухай бүр шинэчилж байна.
- 4.3.2. Хөдөлмөрийн тухай хуулийн өөрчлөлттэй холбогдуулан Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дахин боловсруулах ажил эхлээд байна.
- 4.3.3. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг албадын үйл ажиллагааны онцлогийг харгалзан, албадын ажлын тайланг алба, нэгж бүрээр захирлын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж, ажлын гүйцэтгэлийг нь дүгнэж ажиллалаа.

Тав. Цаг үеийн шаардлагаар хийсэн ажлын үр дүн.

5.1. Улс, Нийслэл, дүүргийн удирдлагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилт.

Дээд газраас ирүүлсэн болон Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Онцгой комисс, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан тоот, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн албан тоот зэрэг нийт **52** шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан болно.

5.2. Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилт.

- 5.2.1. Короновируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр Улсын болон Нийслэлийн Онцгой комиссын даргын тушаалаар батлагдсан түр журам, соёл урлагийн арга хэмжээнд тавигдах тусгай нөхцөл шаардлага, холбогдох үйлчилгээний ерөнхий стандартуудыг мөрдөн ажиллаж байна.
 - Их танхимын үзэгчдийн орох, гарах хэсгийг тусдаа нэг чигийн урсгалтай байхаар зохион байгуулж үзэгч, үйлчлүүлэгчдэд хяналт тавьж ажиллалаа.
 - Тоглолт арга хэмжээ зохион байгуулагч иргэн, ААНБ-тай их танхим ашиглуулах гэрээ байгуулахдаа Түргэвчилсэн шинжилгээ авах лабораторийг ажиллуулах, III тунд хамрагдсан иргэдийг иргэний үнэмлэх болон нэмэлт тунд хамрагдсан гэрчилгээгээ цахимаар эсвэл цаасаар үзүүлж нэвтрүүлэх, нэмэлт III тунд хамрагдаагүй иргэдийг шинжилгээнд хамруулах талаар гэрээнд тусгаж, Түргэвчилсэн шинжилгээний төлбөрийг тоглолт арга хэмжээ зохион байгуулагч иргэн, ААНБ бүрэн хариуцан ажиллаж хэвшлээ.
 - Их танхимын дүүргэлтийг 50%-иас хэтрүүлэхгүй байхаар буюу 1 суудал алгасуулж 1 хүн суулгахаар зохион байгуулалт хийж, хяналт тавьж ажиллаж байна.
 - Орох хэсгийн 2 талд хяналтын ажилтныг ажиллуулж, үйлчлүүлэгчдийн дархлаажуулалтад хамрагдсан байдлыг шалган ажиллаж хэвшлээ.

- Ажилчдын болон үйлчлүүлэгчдийн хаалганы орох, гарах хэсэгт гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай уусмал байршуулж хэвшлээ.
- Тасалбарыг цахимаар авах боломжийг бүрдүүлж, Ticket.mn цахим сайтаар тасалбар худалдаалах зөвлөмж өгч ажиллалаа.
- Ковид-19 коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх, үзэгчдийн үзвэр үзэх соёлыг дээшлүүлэх зорилгоор “Аудио бичлэг”-ийг хийн хүргэж ажиллалаа. Тус аудио бичлэгийг Соёлын Төв Өргөөгөөр үйлчлүүлсэн иргэдэд, үзвэрийн их танхимд тоглолт, жүжиг, хурал, баярын нэгдсэн арга хэмжээний үеэр арга хэмжээ эхлэхээс өмнө тогтмол явуулж хэвшлээ.
- Их танхим, фойе, хүлээлгийн хэсэгт бөөгнөрөл үүсгэхгүй, үзэгч хоорондын зай барих, тэмдэглэгээг байршуулан мөрдүүлж ажиллалаа.
- Ариутгал халдваргүйжүүлэлтийг тухай бүр мэргэжлийн байгууллагаар хийлгэж хэвшлээ.






5.2.2. Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийслэлийн иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах ажилд идэвх санаачлага гарган иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлахад хяналт тавих-**эргүүлийн үүргийг** амжилттай хэрэгжүүлж ажиллалаа.

Улсын Онцгой комисс, Нийслэлийн Онцгой комиссоос өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу, Сүхбаатар дүүргийн 6-р хорооны иргэний танхимын зохион байгуулагч В.Чанцалдулам, хэсгийн ахлагч Б.Энхтуул нарын өгсөн заавар зөвлөмжийн дагуу Нийслэлийн Соёлын Төв Өргөөнөөс "Нэг Хаалга-Нэг Шинжилгээ" аяны үед байгууллагын 14 ажилтан 2021 оны 2 дугаар сарын 11-22-ны өдрүүдэд эргүүл хийж хамтран ажиллалаа. Сүхбаатар дүүрэгт 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдөр "Нэг хаалга- Нэг шинжилгээ" аян явагдсан бөгөөд 6-р хорооны 1 дүгээр хэсэгт шинжилгээ авах ажилд зохицуулагчийн үүрэг гүйцэтгэж ажиллалаа.


"Нэг хаалга-Нэг шинжилгээ" аяны үед айл өрхүүд 99,5%-тай хамрагдаж, амжилттай зохион байгуулж ажиллалаа.

Эргүүлээр ажиллахад ямар нэгэн хүндрэл бэрхшээлтэй зүйл гараагүй бөгөөд Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар болон бусад холбогдох газруудаас өдөр бүр мэдээ авч ажиллаж байсан бөгөөд Сүхбаатар дүүргийн 6-р хорооны ажилтан албан хаагчид бүхий л талаар тусалж дэмжин нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар сайн хангаж ажилласан болно.








5.2.3. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, тархалтын хүрээг нэмэгдүүлэхгүйн тулд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагуудтай хамтран тухай бүр ариутгал халдваргүйжүүлэлтэд байгууллагаа хамруулж, концертын их танхим, гадна болон дотоод орчны талбай бусад өрөө тасалгаа зэрэг нийт 3000 орчим метр квадрат талбайд ариутгал, халдваргүйжүүлэх ажлыг 10 удаа гүйцэтгүүлэн ажиллалаа.



5.2.4. “Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийслэлийн иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах”-д байгууллага, хамт олон идэвхи санаачлага гарган, ариутгал, цэвэрлэгээг чанарын өндөр түвшинд хийх үүргийг амжилттай хэрэгжүүлж ажиллалаа. Маркетинг үйлчилгээний албаны ажиллагсад өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийхийн зэрэгцээ гадна талын хана, хаяавч, “Г” корпусын 1-12 давхарын цонх, тагтнууд, “А”, “Г” корпусын подвальный хэсэгт их цэвэрлэгээ хийж, их танхимын сандлуудыг угаах, наасан бохийг арилгах, “А” зоны 3-р давхрын хивсэнцэр “Г” зоны 1-12 давхрын шат, хана, цонхыг угаах, “А” хэсгийн үзэгчид оруулдаг хаалганыхаа шил толь үүдний хэсгийн хар чулуун шал, цагаан баганууд, их танхимын хивсэнцрийн цэвэрлэгээ, “Г” зоны гадна талын шал эргэн тойрний сараалжин төмөр, хаяавч, цонхны дотор талын тоос шороо цонхны гадна хаалт төмөр, балкон, цонхнууддаа их цэвэрлэгээг хийж гүйцэтгэж ирлээ.



Уран бүтээл техникийн албаны албан хаагчид Техникийн бүрэн бүтэн байдал ямар нэг сааталгүй ажиллах цэвэрлэгээ үйлчилгээ өрөөний эмх цэгцтэй байдлыг хангах зорилгоор склад, техникийн өрөө, тайзны галерей, декорацид цэвэрлэгээ үйлчилгээг хийж ажиллаж байна. Мөн тайзны хөшиг гэрэл чимэглэл зүүдэг штанкет, дуу дуугаралтын тоног төхөөрөмж, уран сайхны гэрэл, ложны выносны гэрэл, цахилгааны утас зэрэгт нарийн цэвэрлэгээ хийж техникийн бүрэн бүтэн байдал, өнгө үзэмжийг муутгайхгүйн тулд ариг гамтай ашиглан тоног төхөөрөмжинд шаардлагатай үйлчилгээг хийж, шатсан гэрлийг солих, эрэг боолт нь суларсан эргийг солих, гэмтсэн утсыг солих зэрэг ажлуудыг хэвшүүлэн хийж гүйцэтгэлээ.




Коронавируст Ковид-19 цар тахлын үед халдвар хамгааллын дэглэмийг сахин, вируст тахлаас урьдчилан сэргийлэхийн тулд байгууллагын тайзны франц хөшиг болон 2 ээлжийн цэнхэр, ягаан, падуг, горизонт, кулис зэргийг угааж цэвэрлэлээ. Үүнд: 18x12-ийн хэмжээтэй 2 том хөшиг, 18x3-ийн хэмжээтэй 10 ширхэг падуг, 4x12-ийн хэмжээтэй 18 ширхэг кулис, нийт 30 ширхэг хөшгийг УБТА, СМА, МҮА-ны ажиллагсад зөөн тээвэрлэж “Өөртөө үйлчлэх угаалгын газар”-т угааж, Наадмын бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.








5.2.5. Нийслэлийн Засаг Даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийг биеийн тамир, идэвхитэй хөдөлгөөнийг энгийн дасгал болох алхалт гүйлтээр хичээллэхэд уриалах, бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл зөв амьдралын дадал хэвшилд сургах зорилгоор Улсын хэмжээнд биеийн дархлааг дэмжих “Эрүүл мэндийн цахим гүйлт 2021” биеийн тамирын үйл ажиллагааг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос 2021 оны 03 дугаар сарын 15-28-ны өдрүүдэд зохион байгуулагдах тухай удирдамж ирсэний дагуу байгууллагынхаа албан хаагчдыг уг арга хэмжээнд амжилттай хамрууллаа.

Коронавируст/ковид-19/ цар тахлын үед байгууллагын ажиллагсадын бие бялдар эрүүл мэнд, дархлааг дэмжиж, биеийн тамир спортоор чийрэгжүүлж, эрүүл мэндийн зөв дадалд сургах зорилгоор 2021 оны 03 дугаар сарын 27-ны өдөр халдвар хамгааллын дэглэмийн хүрээнд цэвэр агаарт явган аялал зохион байгуулж ажиллалаа.




“Эрүүл мэндийн цахим гүйлт 2021” биеийн тамирын үйл ажиллагааны талаарх мэдээллийг нийт албан хаагчдад танилцуулж мэдээллэсэн бөгөөд байгууллагынхаа 5 албан хаагчдыг STRAVA App-ыг ашиглаж, явган аялалд идэвхитэй хамруулж ажиллалаа.

STRAVA аппликейшны алхалтын заалтыг харуулвал:

Д/д	Ажиллагсадын нэрс	STRAVA апп-ын заалт
1	Д.Энхмаа	
2	Д.Гэрэлтуяа	
3	Ц.Пүрэвсүрэн	
4	Ж.Батзаяа	
5	А.Батнягт	

5.2.6. “Жендэрийн тогтсон хэвшмэл буруу ойлголт, тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалтын эсрэг, бүгдээрээ адил тэгш эрх, үүрэг оролцоотой нийгмийг бүтээхийн төлөө хамтдаа нэгдье” уриан дор нэгдэн байгууллагын албан ёсны цахим хуудас болон Facebook хуудсаараа дамжуулан тус аяны талаарх мэдээлэл, фрем, логог байрлуулан олон нийтэд сурталчилан, түгээн дэлгэрүүлж хамтран ажиллалаа.



5.2.7. Коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, үйлчлүүлэгчид болон түрээслэгчдийн аюулгүй байдлыг хангаж болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын “А” зоны их танхимын партер, бельэтаж руу харах чиглэлд, ВИП өрөө, үйлчлүүлэгчдийн болон ажиллагсадын орох, гарах хаалганы чиглэлд гадна болон дотор талд шөнийн хараатай, 5 мегапиксел нягтаршилтай 6 камер нэмэлтээр байршуулж, “Г” зоны үүдний хэсэгт нэмэлтээр 2 камер болон дэлгэц, NVR бичигч, хатуу диск, холбох хэрэгслүүдийг зохих журмын дагуу авч, мэргэжлийн байгууллагаар суурилуулалт хийлгэж, байршуулж ажиллалаа.





5.2.8. “Дасгал хөдөлгөөн хийцгээ” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяны хүрээнд иргэд өдөр тутмын амьдралдаа эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлж биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, бие бялдраа чийрэгжүүлэх, биеийн дархлааг дэмжих аянд Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос ирүүлсэн удирдамжийн дагуу Нийслэлийн Соёлын Төв Өргөөний хамт олон тус арга хэмжээнд идэвхитэй оролцож өдөр тутмын амьдралдаа идэвхитэй хөдөлгөөн алхалтыг хийж хэвшүүлсээр байна.

“Алхах-Гүйх-Дугуй унах” арга хэмжээний гол зорилго нь өнөө цагт дэлхий даяар тархаад буй Коронавируст/ковид-19/ цар тахлын үед хүн бүр хөл хорионд орж идэвхитэй дасгал хөдөлгөөн хийж чадахгүйд хүрч байна. Иймд тус аяны хүрээнд байгууллагын ажиллагсадын бие бялдар эрүүл мэнд, дархлааг дэмжиж, биеийн тамир спортоор чийрэгжүүлж, эрүүл мэндийн зөв дадал хэвшилтэй болж Коронавируст/ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх зэрэг ач холбогдолтой билээ.

Манай байгууллагын захиргааны 5 ажилтан албан хаагч 2021 оны 06 дугаар сарын 26-ны өдөр аюулгүй ажиллагааны дүрэм журам, халдвар

хамгааллын дэглэмийг чанд сахин цэвэр эрүүл агаарт нэг өдөр алхалт хийж дархлаагаа дэмжлээ.



“Дасгал хөдөлгөөн хийцгээ” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяны талаарх мэдээллийг нийт ажилтан албан хаагчдад танилцуулга хийж шаардлагатай зааварчилгаа, зөвлөмж, мэдээ мэдээллийг өгч, “STRAVA” аппликэйшныг хэрхэн ашиглаж, нягтлан бодогч Д.Гэрэлтуяа, зохион байгуулагч Ц.Пүрэвсүрэн, нярав Даш.Энхмаа, Дам.Энхмаа, албаны дарга Д.Баянзул нар оролцож, явган алхалт хийлээ.

STRAVA АППЛИКЭЙШНЫ ЗААЛТ ОРОЛЦОГЧ ТУС БҮРЭЭР:



№	Оролцогчийн нэр	STRAVA АППЛИКЭЙШН ЗААЛТ
1	<p>Д.Гэрэлтуяа</p> 	
2	<p>Ц.Пүрэвсүрэн</p> 	

<p>3 Д.Энхмаа</p> 	
<p>4 Д.Энхмаа</p> 	
<p>5 Д.Баянзул</p> 	



5.2.9. Нийслэлийн Онцгой комиссын баталсан хуваарийн дагуу өрхийн эрүүл мэндийн төвд Коронавирус (КОВИД-19) халдварын үеийн тусламж, үйлчилгээнд дэмжлэг үзүүлэн ажиллах албан хаагчдын нэрсийг хуваарийн дагуу гаргаж, СХД-ийн 28 болон 29-р хороонд 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийн хооронд ажиллаж, угтах үйлчилгээ үзүүлэх, Ковидын багц савлах боох, зөвлөгөө мэдээлэл өгөх зэрэг шаардлагатай ажлуудад дэмжлэг үзүүлэн


ажиллалаа. Тус ажилд байгууллагын 17 албан хаагч оролцсон бөгөөд 2500 гаруй хүнд угтах үйлчилгээ үзүүлж, 1300 ковидын багц савлаж, 1800 гаруй хүнд ковидын зөвлөгөө мэдээлэл үзүүлж ажилласан байна.



5.2.10. Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 15 дугаар тушаалаар дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамрагдалтыг эрчимжүүлэх, зорилгоор Хан-Уул дүүргийн 21, 18 дугаар хороонд сайжруулсан түлшний хэрэглээг эрчимжүүлэх, хяналт тавих зорилгоор тус дүүргийн 21 дүгээр хороонд Нийслэлийн Соёлын Төв Өргөөний 30 ажилтан албан хаагчид ажиллаж байна. Хан-Уул дүүргийн 18-р хороонд 2021 оны 12-р сарын 15-ны өдрөөс эхлэн дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэхэд хяналт тавьж ажилласан бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийг хүртэлх хугацаанд **1211** иргэд дархлаажуулалтын нэмэлт III тунд хамрагдсан байна. Тус хороо нь 60.7 %- тай III тунд хамрагдаад байна.

Хан-Уул дүүргийн 21-р хороонд 2021 оны 12-р сарын 15-ны өдрөөс эхлэн дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэхэд хяналт тавьж ажилласан бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийг хүртэлх хугацаанд **6043** иргэд дархлаажуулалтын нэмэлт III тунд хамрагдсан байна. Бид тус хорооны дархлаажуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор одоогийн байдлаар нэмэлт тунд хамрагдаагүй 200 гаруй иргэд рүү утсаар холбогдож бүүстэр тунд

хамрагдахын ач холбогдлыг зөвлөж ажиллаж байна. Тус хороо нь **74.5%**- тай III тунд хамрагдаад байна. Цаашид иргэдтэй утсаар холбогдож нэмэлт тунд хамрагдахыг уриалж ажиллахаар төлөвлөн ажиллаж байна. Сайжруулсан түлшний хэрэглээг эрчимжүүлэх, хяналт тавих зорилгоор тус



дүүргийн 21 дүгээр хороонд 10.00-16.00 цагийн хооронд өргөөний 6 ажилтан хариуцлагатай ажиллалаа. ХУД-ийн 21-р хороонд ажиллах төлөвлөгөөний дагуу 7-

р хэсгийн ахлагч Г.Мөнхжаргал, 5-р хэсгийн ахлагч Д.Нандин нартай тус хорооны нутаг дэвсгэрт амьдардаг 25 айл өрхөөр орж, сайжруулсан түлшний хэрэглээнд хяналт тавьж ажиллалаа. ХУД-ийн 21 дүгээр хороо нь түлшний цэггүй, тус хороонд ихэвчлэн барилгын манаач хийдэг айл өрхүүд зонхилдог байна. Түүхий нүүрс илрүүлсэн зөрчилгүй, бүх айлууд сайжруулсан түлшээ хэрэглэж хэвшсэн байна.

2021 оны 12-р сарын 15-ны өдрийн байдлаар тус хороонд угаарын хий мэдрэгчтэй 5 айл байсан бөгөөд 4 айлыг угаарын хий мэдрэгчтэй болгож нийт 9 айл болсон байна. Манай байгууллага айл өрхүүдээр хяналт тавьж ажиллахдаа шаардлагатай зөвлөмжүүдийг тухай бүр өгч ажиллаж, угаарын хий мэдрэгчтэй айл өрхийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна. Эко хотхоны айл өрхүүд халаалтандаа цахилгаан халаагуур, камен зуух ашигладаг бөгөөд “Хурх” ХХК-ны үртсэн шахмал түлшийг ашигладаг байна. Ажиллах хугацаанд ямар нэгэн зөрчилгүй илрээгүй, тайван ажиллалаа. /Дэлгэрэнгүй тайланг хавсралтаар үзүүлэв/

5.2.11. Монгол улсын Шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 142 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу өгсөн үүрэг даалгавар чиглэлийн хүрээнд Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороог хариуцан Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын ЭАХХХУАБайцаагч Б.Шинэдаваагаар ахлуулан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын БОХУБайцаагч М.Мөнгөнчимэг, НСТӨ-ний захирал Д.Ариунбаатар, жолооч Ш.Пүрэвдэмбэрэл, 21-р хорооны I болон VII хэсгийн ахлагч О.Буяннэмэх, Д.Мөнхжаргал нарын 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг сайжруулсан түлшний хэрэглээ, зарцуулалт, нөөцөд хяналт тавьж ажиллахаар 2021 оны 01 дүгээр сарын 07-09-ний өдрийн 08.00-20.00 цагийн хооронд хяналт тавьж ажиллалаа. ХУД-ийн 21-р хороонд нийт 10 аж ахуй нэгж, 37 өрх айлаар орж хяналт тавьж ажиллалаа. Хороонд ажиллах хугацаанд түүхий нүүрс илрүүлсэн зөрчил гарсан бөгөөд Морингийн давааны МТ колонкийн хажуугийн хашааг манадаг манаач нь согтуу байж таараад шалгалтын комиссыг элдэв үгээр дрормжилж, хөөж гаргасан байна.



Хан-Ууд дүүргийн 21 дүгээр хорооны иргэдээс түлшний цэг байдаггүй, түлшний хүрэлцээ муу байгаа талаар болон уутны хэмжээ багассан, түлшний чанар өмнөх жилээс муудсан талаар гомдол санал өгсөн байна.



ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ  *Д.Ариунбаатар* Д.АРИУНБААТАР

НЭГТГЭН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН


П.Сэрсмаа

П.СЭРСМАА

Албан хаагчдын сургалтад хамрагдсан дэлгэрэнгүй тайлан

Дээд байгуулагаас цаг үеийн шаардлагаар зохион байгуулагдаж буй сургалт, семинарт тухай бүрд оролцож ирлээ. Тухайлбал:

1. Нийслэлийн засаг даргын тамгын газраас санаачлан, " Менежмент ба ур чадварын хүрээлэн" ТББ-ын зохион байгуулсан "Зөв менежмент-Зөв тогтолцоо" цахим сургалтанд 2021 оны 1 дүгээр сарын 26-нд байгууллагын захирал Б.Байгалмаа, Албаны дарга Д.Баянзул, Зохион байгуулагч Ц.Пүрэвсүрэн, Архив бичиг хариуцсан ажилтан Д.Цогжаргал нар хамрагдлаа.




2. Нийслэлийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан, "Өргөдөл, гомдлын асуудал хариуцсан албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх мэргэжил, арга зүйн" цахим сургалтанд 2021 оны 02 дугаар сарын 01-нд байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан Д.Цогжаргал хамрагдлаа.


3. Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" цахим сургалтад 2021 оны 02 дугаар сарын

09, 10-ны өдөр архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан Д.Цогжаргал хамрагдлаа.

- 4. Сангийн Яамнаас зохион байгуулагдсан Төрийн албаны цалингийн нэгдсэн системээс Си Ти Эс программ руу журналын бичилтийг хэрхэн дамжуулах, гүйлгээ хэрхэн илгээх, цалингийн загвар ба төрлүүдийн тухай цогц сургалтанд 2021 оны 02 дугаар сарын 19,23,25-ны өдрүүдэд ахлах нягтлан бодогч Ө.Цолмон, тооцооны нягтлан бодогч Д.Гэрэлтуяа нар хамрагдлаа.
- 5. Нийслэлийн Архивын газраас Нийслэлийн харъяа газруудын гүйцэтгэх албан тушаалтнуудад зохион байгуулсан Архив албан хэрэг хөтлөлтийн цахим сургалтанд 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр ахлах нябо Ө.Цолмон, тооцооны нябо Д.Гэрэлтуяа, УБТА-ны дарга Д.Баянзул, зохион байгуулагч Ц.Пүрэвсүрэн, бичиг хэргийн ажилтан Д.Цогжаргал нар хамрагдлаа.




- 6. Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас харъяа газруудад 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан “Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн” сургалтанд захирал Б.Байгалмаа, зохион байгуулагч Ц.Пүрэвсүрэн нар хамрагдлаа.




- 7. Нийслэлийн Санхүү Төрийн Сангийн хэлтэс болон Сангийн яамнаас хамтран зохион байгуулсан нягтлан, няравын сургалтад 2021.05.17-2021.05.18-ны өдрүүдэд ахлах нябо Ө.Цолмон, тооцооны нябо

Д.Гэрэлтуяа, нярав Дам.Энхмаа, нярав Даш.Энхмаа нар амжилттай хамрагдлаа.


- Архивын ерөнхий газраас зохион байгуулсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй" анхан шатны сургалтад 2021 дүгээр 04 сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан даргын туслах Д.Цогжаргал амжилттай хамрагдаж төгслөө.



- Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулдаг "Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сургалт"-д 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн ахлах нягтлан бодогч Ө.Цолмон, тооцооны нягтлан бодогч Д.Гэрэлтуяа нар хамрагдлаа.




- "АЛСЫН ХАРАА-2050 Залуучуудын оролцоо" Монгол Улсын Ерөнхий сайд, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн тэргүүн Л.Оюун-Эрдэнийн Залуучуудын хөгжлийн зөвлөлийн гишүүдтэй хийх цахим уулзалт 2021 оны 6 дугаар сарын 04-ний өдөр цахимаар зохион байгуулагдсан бөгөөд НСТӨ-ний дэргэдэх Залуучуудын зөвлөлийн дарга Д.Баянзул болон бусад гишүүд хамрагдлаа.




11. НЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтсээс 2022.01.01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөх зарим хуулиудыг таниулан сурталчлах, нийслэлийн эрх зүйн мэдээллийн сан ub.legal.mn сайтыг танилцуулах зорилгоор нийслэлийн харьяа төсөвт байгууллагуудын албан хаагчдад зохион байгуулсан цахим сургалтад ахлах нябо Ө.Цолмон, тооцооны нягтлан бодогч Д.Гэрэлтуяа, зохион байгуулагч Ц.Пүрэвсүрэн нар амжилттай хамрагдлаа.


12. НЗДТГ-аас Нийслэлийн Прокурорын газартай хамтран “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах нь” сэдэвт сургалтыг 2021 оны 10-р сарын 06-ны өдөр цахимаар зохион байгуулсан бөгөөд тус сургалтад тооцооны нябо Д.Гэрэлтуяа, зохион байгуулагч Ц.Пүрэвсүрэн нар амжилттай хамрагдлаа.



13. Авилгатай тэмцэх газраас 2021 оны 11-р сарын 16-ны өдөр Төрийн байгууллагын албан хаагчдад зохион байгуулсан сургалтад байгууллагын нийт 8 албан хаагчид хамрагдлаа. Тус сургалтад захирал Д.Ариунбаатар, орлогч дарга Н.Энхбат, ахлах нягтлан бодогч Ө.Цолмон, тооцооны нягтлан бодогч Д.Гэрэлтуяа, зохион байгуулагч Ц.Пүрэвсүрэн, хуулийн зөвлөх П.Сэрсмаа, нярав Даш.Энхмаа, нарийн бичиг Э.Энхжаргал нар тус тус амжилттай хамрагдлаа.



14. ХНХЯ, НЗДТГ, НАОЭХ, НҮБҮЭХ-ээс Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад хамтран зохион байгуулсан “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг танилцуулсан сургалтад 2021 оны 11-р сарын 16-ны өдөр дэд захирал Н.Энхбат амжилттай хамрагдлаа.



15. Соёлын яам, “Соунд Монголиа” ХХК хамтран Соёлын Төв Өргөөний их танхимын тайзнаа мэргэжлийн урлагийн байгууллагууд, орон нутгийн театрын дуу шум, гэрэл техникийн ажилчдад зориулсан мастер класс сургалтуудыг 2021 оны 11-р сарын 01-04-ний өдрүүдэд явуулсан бөгөөд тус сургалтад манай байгууллагын Уран бүтээл техникийн албаны 4 ажилтан амжилттай хамрагдлаа.



16. Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо – Ажилтан албан хаагчдын үйлдвэрчний эвлэлийн хорооноос зохион байгуулсан IX бага хуралд 2021.11.20-нд маркетингийн ажилтан Д.Баянзул амжилттай хамрагдлаа.



17. Соёлын яамны дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлийн Соёлын бүтээлч сар аяны хүрээнд Соёл урлагийн байгууллагын ажилтнуудын дунд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн зөвлөгөөнд 2021 оны 11-р сарын 11-ний өдөр маркетингийн ажилтан Д.Баянзул биечлэн оролцож, тооцооны нябо Д.Гэрэлтуяа, зохион байгуулагч Ц.Пүрэвсүрэн нар цахимаар хамрагдлаа.



Цаг үеийн шаардлагаар дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг дэлгэрэнгүй харуулбал:

Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 15 дугаар тушаалаар дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамрагдалтыг эрчимжүүлэх, зорилгоор Хан-Уул дүүргийн 21, 18 дугаар хороонд сайжруулсан түлшний хэрэглээг эрчимжүүлэх, хяналт тавих зорилгоор тус дүүргийн 21 дүгээр хороонд Нийслэлийн Соёлын Төв Өргөөний 30 ажилтан албан хаагчид ажиллаж байна. Хан-Уул дүүргийн 18-р хороонд 2021 оны 12-р сарын 15-ны өдрөөс эхлэн дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэхэд хяналт тавьж ажилласан бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийг хүртэлх хугацаанд **1211** иргэд дархлаажуулалтын нэмэлт III тунд хамрагдсан байна. Тус хороо нь 60.7 %- тай III тунд хамрагдаад байна.

Хан-Уул дүүргийн 21-р хороонд 2021 оны 12-р сарын 15-ны өдрөөс эхлэн дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэхэд хяналт тавьж ажилласан бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийг хүртэлх хугацаанд **6043** иргэд дархлаажуулалтын нэмэлт III тунд хамрагдсан байна. Бид тус хорооны дархлаажуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор одоогийн байдлаар нэмэлт тунд хамрагдаагүй 200 гаруй иргэд рүү утсаар холбогдож бүүстэр тунд хамрагдахын ач холбогдлыг зөвлөж ажиллаж байна. Тус хороо нь **74.5%**- тай III тунд хамрагдаад байна. Цаашид иргэдтэй утсаар холбогдож нэмэлт тунд хамрагдахыг уриалж ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

Нэмэлт тунгийн дархлаажуулалтын хүрээнд:

Хан-Уул дүүргийн 18 дугаар хорооны хэсгийн ахлагч Цэдэвсүрэн, Оюунчимэг, Ганчимэг нартай тус хооронд байрлах **50** аж ахуй нэгж байгууллагаар 13.00-16.00 цагийн хооронд орж хяналт тавьж, нэмэлт тунд хамрагдаагүй албан хаагчдад вакциндаа идэвхитэй хамрагдах талаар уриалж, хорооны өрхийн эмнэлэгт 09.00-20.00 цагийн хооронд харъяа харгалзахгүй хийж байгаа талаар заавар зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Дээрх **50 аж ахуй нэгж байгууллагуудад** нийт **401** ажилтан албан хаагч байгаагаас:

- Дархлаажуулалтын нэмэлт 3 дугаар тунд **250** ажилтан албан хаагч хамрагдаж,
- Дархлаажуулалтад хамрагдаагүй **151** ажилтан албан хаагч байна.
 - Ковид-19 цар тахлаар өвчлөөд, дархлаажуулалтын III тунд хамрагдах хугацаа болоогүй **54** ажилтан,

- эрүүл мэндийн шалтгаантай **48** ажилтан,
- татгалзсан **49** ажилтан байхгүй байна.

Судалгаагаар **67** ажилтан, албан хаагч цаашид III тунд хамрагдах төлөвтэй байна. Аж ахуй нэгж байгууллагаас явуулын баг авах хүсэлт гаргаагүй.

Хан-Уул дүүргийн 18-р хороонд 2021 оны 12-р сарын 15-ны өдрөөс эхлэн дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэхэд хяналт тавьж ажилласан бөгөөд 01 дүгээр сарын 14-ны өдрийг хүртэлх хугацаанд **1211** иргэд дархлаажуулалтын нэмэлт III тунд хамрагдсан байна.

Тус хороо нь 51.3%- тай III тунд хамрагдсан байна.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 18-Р ХОРОО

№	Аж ахуйн нэгж байгууллага хорооны дугаар	Нийт иргэн/ажилчдын тоо/	3-р тунд хамрагдсан хүний тоо	Хамрагдаагүй хүний тоо	3-р тунд хамрагдаагүй шалтгаан			3-р тунд хамрагдах хүний тоо	Явуулын баг авах захиалга /ААНБ-ын хувьд/
					Хоног болоогүй	Эрүүл мэндийн	Татгалзсан		
1	2021.12.16 Хан-Уул дүүргийн 18-р хороо	1992	732	1260	6	19	6	1229	Байхгүй,
2	2022.01.06 Хан-Уул дүүргийн 18-р хороо	1,992	1023	969	31	40	22	876	Байхгүй,
	Дүн		291	291				353	

ХУД-ийн 21-р хороонд ажиллах төлөвлөгөөний дагуу хорооны 6-р хэсгийн ахлагч Б.Тунгалагтай, 18 дугаар хэсгийн ахлагч Оюунчимэг нартай хамтран 10.00-16.00 цагийн хооронд тус хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй **54** ААНБ-аар явж вакциний тоон мэдээг гаргаж, вакцинд хамрагдалтыг эрчимжүүлэхэд анхаарч ажиллалаа.

Дээрх **54** аж ахуй нэгж байгууллагуудад нийт **270** ажилтан албан хаагч байгаагаас:

- Дархлаажуулалтын нэмэлт 3 дугаар тунд **181** ажилтан албан хаагч хамрагдаж,
- Дархлаажуулалтад хамрагдаагүй **89** ажилтан албан хаагч байна.
 - Ковид-19 цар тахлаар өвчлөөд, дархлаажуулалтын III тунд хамрагдах хугацаа болоогүй **19** ажилтан,
 - эрүүл мэндийн шалтгаантай **37** ажилтан,
 - татгалзсан **33** ажилтан байхгүй байна.

Судалгаагаар **28** ажилтан, албан хаагч цаашид III тунд хамрагдах төлөвтэй байна.

Аж ахуй нэгж байгууллагаас явуулын баг авах хүсэлт гаргаагүй.

III тунд хамрагдахаас татгалзсан болон өвчлөөд эдгэрээд 21 хоног болоогүй байгаа албан хаагчдад вакциндаа идэвхитэй хамрагдах талаар уриалж, 21-р хорооны өрхийн эмнэлэгт 09.00-20.00 цагийн хооронд харъяа харгалзахгүй хийж байгаа талаар заавар зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Зарим Аж ахуй нэгж байгууллагын ажиллагсад вакцины нэмэлт III тунд хамрагдахыг уриалахад

- Вакцин хийлгэх үгүй нь хувь хүний эрхийн асуудал
- Хүний эрхэнд халдаж байна гээд хамрагдсан үгүйг хэлэхгүй
- Төрийн байгууллагын ажилчид хийх ажилгүй дээ, ингэж явдаг юмуу гэх мэтчилэн доромжилсон үл ойшоосон хандлагатай байсан юм.

Хан-Уул дүүргийн 21-р хороонд 2021 оны 12-р сарын 15-ны өдрөөс эхлэн дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэхэд хяналт тавьж ажилласан бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийг хүртэлх хугацаанд **6043** иргэд дархлаажуулалтын нэмэлт III тунд хамрагдсан байна.

Тус хороо нь 72.9%- тай III тунд хамрагдсан байна.

Цаашид иргэдтэй утсаар холбогдож нэмэлт тунд хамрагдахыг уриалж ажиллахаар төлөвлөсөн байгаа.

№	Аж ахуйн нэгж байгууллага хорооны дугаар	Нийт иргэн/ажилчдын тоо/	3-р тунд хамрагдсан хүний	Хамрагдаагүй хүний тоо	3-р тунд хамрагдаагүй шалтгаан			3-р тунд хамрагдах хүний	Явуулын баг авах захиалга /ААНБ-ын хувьд/
					Хоног болоогүй	Эрүүл мэндийн	Татгалзсан		

			ТОО					ТОО	
1	2021.12.16 Хан-Уул дүүргийн 21- р хороо	8108	5805	2303	31	40	205	2058	Байхгүй,
2	2022.01.06 Хан-Уул дүүргийн 21- р хороо	8,108	5,916	2,192	31	40	205	1,916	Байхгүй,
	Дүн		111	111				142	

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 21-Р ХОРОО

САЙЖРУУЛСАН ТҮЛШНИЙ ХЭРЭГЛЭЭНД:

Сайжруулсан түлшний хэрэглээг эрчимжүүлэх, хяналт тавих зорилгоор тус дүүргийн 21 дүгээр хороонд 2021 оны 12 дугаар сарын 23-ний өдөр 10.00-16.00 цагийн хооронд өргөөний тооцооны нягтлан бодогч Д.Гэрэлтуяа, нярав Дам.Энхмаа, нар тус тус хариуцлагатай ажиллалаа.

ХУД-ийн 21-р хорооны түлш хэрэглэдэг айл өрхүүдээр хяналт тавьсан мэдээ


Дүүрэг, Хариуцсан хороо	Нэрс	Яндантай өрхийн тоо	Угаарын хий мэдрэгчт эй өрхийн тоо	Угаарын хий мэдрэгчгүй өрхийн тоо	Тайлбар
ХУДүүрэг 21 дүгээр хороо	Я.Мөнхжаргал	1	0	1	
	Д.Батсайхан	1	0	1	
	Д.Мөнхбат	1	0	1	
	Д.Гантулга	1	0	1	
	Говь Хангай буйдангийн үйлдвэр	1	1	0	
	Г.Цолмон				Хурхын эко түлш хэрэглэдэг
	Э.Батзаяа				Цахилгаан халаагуураар камень зуух хэрэглэдэг
	Г.Ганзориг	1	0	1	
	М.Нямдорж	1	0	1	
	Тогтохбаяр	1	0	1	Гал түлдэггүй, түлш хэрэглэдэггүй, 13- р Цэргийн анги, Эрчис-тал ХХК
	Ц.Галбадрах	1	0	1	Ахмадын сувилал
	Д.Дарханбаата р	1	0	1	Шинэ үе констракшн
	Нарангэрэл	1	1	0	Тэм Эм ХХК
	Мөнх-Эрдэнэ	1	0	1	Бат Бинг ХХК
	Хувьзаяа	1	0	1	Аэрдром ХХК
	Бавуу	1	0	1	Аэрдром ХХК
	Г.Жамбалням	1	1	0	Эрчим
	О.Наранцогт	1	0	1	
	Ганбат	1	0	1	
	Н.Даваадорж	1	1	0	

Д.Мягмардорж	1	1	0	
Д.Мөнх-Эрдэнэ	1	1	0	Аэрдром ХХК
Гүррагчаа	1	1	0	
А.Солонго	1	1	0	
Ч.Батцоож	1	1	0	
С.Ариунболд	1	1	0	
Батжаргал	1	0	1	
Дүн	25	10	15	

ХУД-ийн 21-р хороонд ажиллах төлөвлөгөөний дагуу 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хорооны 7-р хэсгийн ахлагч Г.Мөнхжаргал, 5-р хэсгийн ахлагч Д.Нандин нартай тус хорооны нутаг дэвсгэрт амьдардаг 25 айл өрхөөр орж, сайжруулсан түлшний хэрэглээнд хяналт тавьж ажиллалаа. ХУД-ийн 21 дүгээр хороо нь түлшний цэггүй, тус хороонд ихэвчлэн барилгын манаач хийдэг айл өрхүүд зонхилдог байна. Түүхий нүүрс илрүүлсэн зөрчилгүй, бүх айлууд сайжруулсан түлшээ хэрэглэж хэвшсэн байна.

Анх 12-р сард Угаарын хий мэдрэгчтэй 5 айл байсан бөгөөд 4 айлыг угаарын хий мэдрэгчтэй болгож нийт 9 айл болсон байна. Манай байгууллага айл өрхүүдээр хяналт тавьж ажиллахдаа шаардлагатай зөвлөмжүүдийг тухай бүр өгч ажиллаж, угаарын хий мэдрэгчтэй айл өрхийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах болно. 21-р хорооны тухайд ихэнх айл нь объект манадаг байнгын байдаггүй айлууд байсан.

Түлш хэрэглэдэг айл өрхүүдийн хоорондын байршил хол, хэд хэдэн айлууд цоожтой эзэнгүй байлаа, хороонд угаарын хий мэдрэгчтэй 9 айл өрх, угаарын хий мэдрэгчгүй 45 айл өрхтэй гэсэн судалгаатай бөгөөд 2021 оны 12-р сарын 23-ны өдөр хяналт тавьсан нийт 25 айл өрхүүдээс 9 айл угаарын хий мэдрэгчтэй, үлдсэн 16 айл өрх угаарын хий мэдрэгчгүй байлаа. Угаарын хий мэдрэгчтэй айл өрхүүдэд угаарын мэдрэгчийг зөв зохистой ашиглах талаар заавар зөвлөгөө өгч, угаарын хий мэдрэгчгүй айл өрхүүдэд эрсдлээс сэргийлэхийн тулд угаарын хий мэдрэгчийг хурдан авч хэрэглэх талаар зөвлөмж өгч ажиллалаа. Тус хороонд байрлах Эко хотхоны айл өрхүүд халаалтандаа цахилгаан халаагуур, камен зуух ашигладаг бөгөөд “Хурх” ХХК-ны үртсэн шахмал түлшийг ашигладаг байна. Ажиллах хугацаанд ямар нэгэн зөрчилгүй илрээгүй, тайван ажиллалаа.



5.1.1. Монгол улсын Шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 142 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу өгсөн үүрэг даалгавар чиглэлийн хүрээнд Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороог хариуцан Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын ЭАХХХУАБайцаагч Б.Шинэдаваагаар ахлуулан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын БОХУБайцаагч М.Мөнгөнчимэг, НСТӨ-ний захирал Д.Ариунбаатар,

жолооч Ш.Пүрэвдэмбэрэл, 21-р хорооны I болон VII хэсгийн ахлагч О.Буяннэмэх, Д.Мөнхжаргал нарын 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг сайжруулсан түлшний хэрэглээ, зарцуулалт, нөөцөд хяналт тавьж ажиллахаар 2021 оны 01 дүгээр сарын 07-09-ний өдрийн 08.00-20.00 цагийн хооронд хяналт тавьж ажиллалаа.

ХУД-ийн 21-р хороонд нийт 37 өрх айлаар орж хяналт тавьж ажиллалаа.


- **Зуухны төрөл:** Энгийн зуух- 26, сайжруулсан зуух – 9, нам даралтын – 0
- **Түлшний хэлбэр:** Сайжруулсан – 37, мод – 5
- **Утаа мэдрэгчтэй өрх айлын тоо** – 5 айл
- Нийт 10 аж ахуйн нэгж байгууллагад хяналт тавин ажиллалаа.
 - **Зуухны төрөл:** 0-15 квт – 6 байгууллага, 15-100 квт – 1 байгууллага , 100-с дээш квт– 3 байгууллага байна.
 - **Түлшний хэлбэрийн хувьд** сайжруулсан түлш болон мод хэрэглэдэг 10 ААНБ байна.
 - **Утаа мэдрэгчтэй байгууллагын тоо** – 4 байгууллага

ХУД-ийн 21-р хорооны 7-р хэсгийн “Жаргалант Эко” хотхоны 1-5 Д.Бавуу энгийн зуух, мод түлж байна. Говь Хангай мебель ХХК, Говь хангай буйдан ХХК нам даралтын 100 квт зуух хэрэглэж сайжруулсан түлш түлж, Монгол Кореа сторе 88 квтын нам даралтын зуух ашиглаж сайжруулсан түлш түлж байна. Эко хотхоны оршин суугчид камен зуух ашигладаг бөгөөд “Хурх” ХХК-ны сайжруулсан түлшийг хэрэглэж, халаагуур ашиглаж халаалтаа шийдсэн байна.

Хороонд ажиллах хугацаанд түүхий нүүрс илрүүлсэн зөрчил гарсан бөгөөд Морингийн давааны МТ колонкийн хажуугийн хашааг манадаг манаач нь согтуу байж таараад шалгалтын комиссыг элдэв үгээр дрормжилж, хөөж гаргасан байна.



Хан-Ууд дүүргийн 21 дүгээр хорооны иргэдээс түлшний цэг байдаггүй, түлшний хүрэлцээ муу байгаа талаар болон уутны хэмжээ багассан, түлшний чанар өмнөх жилээс муудсан талаар гомдол санал өгсөн байна.





**“ХОТЫН СОЁЛ” АЯНЫ “СОЁЛТОЙ БОЛГОЁ” уриан дор зохион байгуулагдсан
ажлын тайлан**

Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/302 дугаар захирамжийн дагуу иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, хотын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн “Хотын соёл” аяныг “Соёлтой БолГоё” уриан дор Нийслэлийн Соёлын Төв Өргөө төлөвлөгөө гарган дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 1-н хүрээнд

Иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, хотын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн “Хотын соёл” аяныг “Соёлтой Болгоё” уриан дор байгууллагын www.stu.ub.gov.mn Вэбсайт-р дамжуулан иргэдийн үзвэр үзэх соёлыг дээшлүүлэх, хотын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээ мэдээллүүдийг 7 хоног бүр байгууллагын албан ёсны Вэбсайтайд байршуулж ажиллалаа.

№	Сэдвийн нэр	Цахим хуудсын нэр
1	Үзвэр үзэхдээ цагаасаа хоцрохгүй байж сурцгаая.	Stu.ub.gov.mn-Соёл урлагийн мэдээлэл цэс
2	Үзвэрийн дундуур хоорондоо ярихгүй байцгаая.	Stu.ub.gov.mn-Соёл урлагийн мэдээлэл цэс
3	Үзвэр үзэхдээ утсаар ярихгүй байж бусдыгаа хүндэтгэе.	Stu.ub.gov.mn-Соёл урлагийн мэдээлэл цэс
4	Тоглолтын танхимд хурц үнэртэй хоол хүнсний зүйл идэхгүй байцгаая.	Stu.ub.gov.mn-Соёл урлагийн мэдээлэл цэс
5	Үзвэрийн дараа өлгүүр лүү битгий яараарай.	Stu.ub.gov.mn-Соёл урлагийн мэдээлэл цэс
6	Тоглолтын танхимд суудлын араас өшиглөхгүй байцгаая.	Stu.ub.gov.mn-Соёл урлагийн мэдээлэл цэс
7	Үзвэр үзсэн танхимдаа хогоо битгий хаяарай.	Stu.ub.gov.mn-Соёл урлагийн мэдээлэл цэс
8	“Лифтэнд суух, буух” соёл	Stu.ub.gov.mn-Соёл урлагийн мэдээлэл цэс
9	"Баруун гарын дүрэм"	Stu.ub.gov.mn-Соёл урлагийн мэдээлэл цэс
10	Та зогсож болно, Гэхдээ бусдад саад болохгүйгээр	Stu.ub.gov.mn-Соёл урлагийн мэдээлэл цэс
11	Нэгнийхээ биед аль болох хүрэхгүй байх нь соёл	Stu.ub.gov.mn-Соёл урлагийн мэдээлэл цэс
12	Олон нийтийн газар ялгадсаа гаргалгүй тэвчих нь соёл	Stu.ub.gov.mn-Соёл урлагийн мэдээлэл цэс

Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2-н хүрээнд

Хотын соёл аяны хүрээнд үзвэрийн их танхимд Ковид-19 коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх, үзэгчдийн үзвэр үзэх соёлыг дээшлүүлэх зорилгоор “Аудио

бичлэг”-ийг хийн хүргэж ажиллалаа. Тус аудио бичлэгийг Соёлын Төв Өргөөгөөр үйлчлүүлсэн үзвэрийн их танхимд тоглолт, жүжиг, хурал, баярын нэгдсэн арга хэмжээний үеэр арга хэмжээ эхлэхээс өмнө тогтмол явуулж хэвшлээ.

Хотын соёл аяны аудио бичлэгийн дуу бичлэг текст

Соёлын Төв Өргөөгөөр үйлчлүүлж байгаа эрхэм хүндэт үзэгчид та бүгдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна.


Эрхэм үзэгч та дараах зөвлөмжүүдийг дагаж мөрдөн нийслэл хотын соёлтой үзэгчдийн тоог нэгээр нэмэгдүүлнэ гэдэгт бид итгэж байна.








1. Та үзвэр эхлэхээс 15 минутын өмнө суудлаа эзэлнэ үү.
2. Та гадуур хувцсаа манай үүдний хэсэгт байрлах өлгүүрт өлгүүлээрэй.
3. Үзэгч та хүндэтгэх шалтгааны улмаас хоцорсон тохиолдолд манай үйлчлэгчээс хаана суух мэдээллээ аван үзэгчид рүү харж, уучлалт гуйн зөрөх нь зүйтэй.
4. Үзвэрийн танхимд орохдоо та утасныхаа дууг хаана уу. Утсаа оролдох, жүжигчдийн зургийг авах, бичлэг хийхийг хатуу хориглодог бөгөөд утасны хэт тод гэрэл нь бусад үзэгчдийн анхаарлыг сарниулж тэдэнд саад болдог гэдгийг анхаараарай.
5. Оройн үзвэрт бага насны хүүхэд дагуулж ирэхгүй байх, учир нь үзвэрийн үеэр чанга хөгжмийн дуунд хүүхэд тань цочиж уйлахаас гадна бусад үзэгчдийн тав тухыг алдагдуулдаг юм шүү.
6. Та бусдыг хүндэтгэх үүднээс хоол хүнсний зүйл үзэгчдийн танхим руу битгий авч ороорой. Үзвэрийн үеэр хоол идэх, чихрийн цаас шажигнуулан дуугаргах, хоорондоо ярих нь бусдад таагүй сэтгэгдэл төрүүлдэг юм шүү.
7. Үзэгч та идсэн чихрийн цаас, зажилсан бохиныхоо хогийг суудал дороо хаяхгүй байх, энт тэнд наахгүй байхыг хүсье.
8. Хувцасны өлгүүр лүү бүү яараарай. Жүжигчид уран бүтээлчдэдээ алга нижигнүүлэн ташиж баяр хүргээрэй.
9. Танхимаас гарахдаа үзэгч та хогоо зориулалтын хогийн саванд нь хийнэ үү.

Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 3-н хүрээнд


Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл урлагийн газраас бэлтгэсэн иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр бүтээсэн нөлөөллийн контент, нэвтрүүлэг, зурагт хуудсыг өөрийн байгууллагын албан ёсны “Нийслэлийн Соёлын Төв Өргөө” Facebook хуудсаар дамжуулж иргэд олон нийтэд хүргэж ажиллалаа.


Manage Page

-  Нийслэлийн Соёлын Төв Өргөө

-  Home
-  News Feed
8 new
-  Inbox
3 new comments
-  Podcasts
-  Business Apps
-  Manage Jobs
-  Notifications

#ӨлөнНийтийнГазар #ҮйлчилгээнийГазар #ЗамынХоргоогчон #НийтийнТээвэр #ЦахимӨрчин





Нийслэлийн Соёлын Төв Өргөө
Create @Username · Palace

Edit Send message

№	Сэдвийн нэр	Цахим хуудсын нэр
1	Хотын иргэн соёлтой байх ёстой. Соёл нь хогоо ангилж хаяхаас эхэлнэ.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
2	Иргэн таны гаргаж буй энгийн үйлдэл бүр Их хотын соёлыг илтгэдэг.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
3	Баруун гарын дүрмээ бариарай.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
4	Хүний ухамсартай үйлдлүүд, дадал зуршлыг соёл хэмээн ойлгож болно.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
5	Хүн болгон харилцан адилгүй ч хотын соёлын үрийг тарихад та эхлэл нь ч байж чадна.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
6	Хүнд талархаж чаддаг, бас төвөг учруулсныхаа төлөө уучлал гуйж чаддаг бол та үнэхээр хүндэлмээр нэгэн юм.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
7	Хотын иргэн таны нийгмийн харилцааны соёлтой эсэх нь энгийн зүйлээс харагддаг.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
8	Хүүхдүүд чихрийн цаасаа хаядаггүй кармалдаг болсон. Энэ нь хотын иргэн болж, хүмүүжиж байна гэсэн үг юм.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
9		Нийслэлийн Соёлын Төв Өргөө

	Та нийгмийн харилцааны соёлын талаар хэр мэдлэгтэй вэ.	Өргөө
10	Үүрийн гэгээгээр өөрийнхөө гэрийг ч цэвэрлэж амжилгүй ажилдаа гардаг цэвэрлэгч нарт бид хүндэтгэлтэй хандах ёстой.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
11	Хүмүүс ээ өөрсдийнхөө эрүүл мэндийн төлөө хогоо заавал хогийн саванд хийж байгаарай.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
12	Залуучууд маань их гоё соёлтой болсон байна.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
13	Хотын түүхийг хоёр минутад - Гандантэгчэнлин хийд"	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
14	Бид өглөө эртлэн босч Нийслэл хотынхоо цэвэр, цэмцгэр байдлын манаанд гардаг.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
15	Цагаан шугам давж зогсдоггүй Явган хүний гарц таглаж зогсдоггүй БолГоё.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
16	Ил задгай асаасан гал, үнс нурмаа бүрэн гүйцэд унтраадаг БолГоё.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
17	Амралтын цагаар чанга дуу, чимээ гаргаж, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулдаггүй БолГоё.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
18	Иргэн таны гаргаж буй энгийн үйлдэл бүр Их хотын соёлыг илтгэдэг.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
19	Хүүхэд багачууд бид соёлтой хотод амьдрахыг хүсдэг . Соёлтой хотод хамтдаа амьдарцгаая.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
20	Автобусны буудал дээр тамхи татдаггүй БолГоё.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
21	Авто замын харилцааны соёл.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
22	Номын нийслэл Улаанбаатар Соёлтой БолГоё.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
23	Автобусаар зорчихдоо суудал тавьж өгдөг БолГоё.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө
24	Урлагийн хот Улаанбаатар Соёлтой БолГоё.	Нийслэлийн Соёлын Төв Өргөө

25	Их хотын иргэн бүр Соёлтой БолГоё.	Нийслэлийн Өргөө	Соёлын	Төв
26	Амьдрах орчны соёл	Нийслэлийн Өргөө	Соёлын	Төв

